



ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААТАЙ ТЭМЦЭХЭД ОРОН НУТГИЙН ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ БОЛОН ОЛОН
НИЙТИЙН ЦАГДАА НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Ж. Жаргал



© Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, 2021

Тайлан

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй олон улсын туршлага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмж.

Эш татах бичвэр

Ж. Жаргал. (2021) Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй олон улсын туршлага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмж. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Улаанбаатар, Монгол улс.

Тайлангийн асуудлаар холбогдох хаяг

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал
У. Тунгалаг Цахим шуудан: tungalag.ulambayar@zsl.org

2021 онд Улаанбаатар хотод хэвлэв.

Татгалзал

Тайланд дурдсан үр дүн, дүгнэлтүүд нь Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн байр суурийг илэрхийлээгүй болно. Энэхүү тайлан дахь мэдээ мэдээллийн үнэн бодит байдалд Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг баталгаа гаргахгүй.

Хуулбарлах тухайд

Энэхүү тайлан зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд зохих зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь хуулбарлах, хөрвүүлэх нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэлд тооцогдоно. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн зүгээс энэхүү тайланг түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмжиж, тайланг хэсэгчлэн нийтлэх тухай зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих зөвшөөрлийг даруй олгоно. Тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах эсвэл дахин хэвлэх зөвшөөрөл авах бол бүрэн мэдээлэл бүхий хүсэлтээ Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгт илгээнэ үү

Тайлангийн дизайныг Ж. Жаргал бэлтгэсэн болно.



Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн
Монгол дахь төлөөлөгчийн газар,
Монре импекс ХХК-н байр, 302 тоот өрөө, Бага тойруу-47,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар Хот, Монгол улс. Утас: 77111138



ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААТАЙ ТЭМЦЭХЭД
ОРОН НУТГИЙН ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ
ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон
олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмж

Ж. ЖАРГАЛ

2021 он



Summary

This report compiled international experiences that involve local communities in combating against illegal wildlife trade and provide recommendations for local People's Representative Meetings and public police officer.

Following conclusion was made:

1. Based on our research on international experiences, effective measures for combating against illegal wildlife trade are more focused on providing national level policy, reducing demand of illegal wildlife products, enhancing law enforcement, and improving involvement of local communities.
2. Design of models that involves local communities for combating against poaching and illegal wildlife trade requires to consider local livelihood needs, to be harmonized with special cultural, traditional, socio-economic characteristics, to introduce positive interventions and to provide tangible benefits for local communities. Engaging them in early stages of designing

and planning and using more participatory approaches, defining targets wisely, mobilizing and improving local capacity, raising awareness by themselves are more likely to bring substantial achievements. Gaining local people's trust, building long-term collaboration, providing gender equality, using advanced communication technology that modified in local condition and protecting informants from any risk are key elements of success in most of international case studies.

We provided forty seven recommendations for local People's Representative Meetings and public police officers that included in two chapters and seven sections. These recommendations are in line with situation in Mongolia and right and duties of local People's Representative Meetings and public police officers, and it is based on research findings, therefore it is perfectly feasible to implement.



АГУУЛГА

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг болон төслийн товч танилцуулга	6
“Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн товч танилцуулга	8
Тайлангын товч танилцуулга	12
Ажлын үндэслэл	13
Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх талаарх олон улсын туршлага	16
Нэгдсэн бодлогоор хангах	17
Зэрлэг амьтны эд эрхтэнийг хэрэглэгч талын эрэлтийг бууруулах	19
Хуулийн хэрэгжилтийг сайжруулах	19
Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллах	19
Нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх арга замууд	20
Зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах чиглэлээр нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй олон улсын туршлага	26
Мексик улсын Яакатанд (Yucatan) “далайн өргөст хэмх” хэмээх амьтны хууль бус худалдааг илрүүлэхэд нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй туршлага	28
Намиби улсад 1993 оноос одоог хүртэл хэрэгжижүүлж буй туршлага	30
Кени улсын хойд бэлчээр нутгийн туршлага	30
Өмнөд Африкийн “Хар Мамбанууд нэртэй хулгайн агнуур болон зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх нэгж”-ийн туршлага	32
Хойд Конго-Браззавил нутгийн уугуул иргэд Мбэнджеличүүдтэй хамтран ажилласан Конго улсын туршлага	34
Зүүн Африкийн Танзани улсын туршлага	36
Непал улсын Читваны байгалийн цогцолборт газарт хирсний хулгайн агнуур, хууль бус худалдааг бууруулсан туршлага	38
Олон улсын туршлагаудаас санаа авч цаашид анхаарах шаардлагатай сургамжууд	42
Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдийг идэвхтэй оролцуулж, амжилтанд хүрэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүд	43

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмжийн тухай	48
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгөх зөвлөмжийн тухай	48
Олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмжийн тухайд	52
ДҮГНЭЛТ	
НОМ ЗҮЙ	59
	61



Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг болон төслийн товч танилцуулга



Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН) нь 1826 онд байгуулагдсан бөгөөд 50 гаруй улс оронд байгаль хамгааллын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, олон улсын байгаль хамгааллын арвин туршлагатай байгууллага юм.

Тус нийгэмлэг нь 2003 оноос хойш Монгол Улсын Их Сургууль (МУИС)-тай хамтран Степ Форвард Хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж, байгаль хамгааллын чиглэлээр суралцаж буй оюутан залуус, байгаль хамгаалагч нарт экологи, байгаль



© Д. /Жагвасүрэн

хамгааллын чиглэлээр зуны сургалт зохион байгуулан, Монгол улсын хөхтөн, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид, загас болон ховор ургамлын ховордлын зэргийг олон талт оролцоог ханган үнэлж, Улаан данс болон хамгааллын төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулан, Монгол улсад байгаль хамгааллын чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн байна.

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг нь 2018 онд Монгол улсад төлөөлөгчийн газраа байгуулан зэрлэг амьтны тоо толгойг зургийн индекс ашиглан үнэлэх, зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах чиглэлээр төслүүд хэрэгжүүлсэн.

“Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн товч танилцуулга

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг нь “Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийг Байгаль орчин аялал жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн Цагдаагийн алба, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Хил хамгаалах

хүчин, Монголын жендерийн тэгш байдлын төв зэрэг байгууллагуудтай хамтран 2018 оноос хэрэгжүүлж байна.

“Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн зорилго нь хууль сахиулах байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх, Монгол Улсын хил дагуу байрших гол гурван цэгт явуулах үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах,



орон нутгийн иргэдийн хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэх жишиг бий болгох явдал юм.

Төслийн үйл ажиллагааг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Замын-Үүд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт хилийн боомтуудад төвлөрүүлэн хэрэгжүүлж байна.

Төсөл дараах зорилтуудыг тавин хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хил дээр үүрэг гүйцэтгэж буй нохдыг хариуцсан нэгжийн Монгол улсын эмзэг хэсгийн хилийн боомт дахь зэрлэг ан амьтдыг хил дамнуулан худалдаалах явдлыг таслан зогсоох чадварыг сайжруулах.

2. Мэргэшсэн гааль, цагдаа, хил хамгаалах байгууллагуудын оролцооноос бүрдсэн зэрлэг ан амьтдын хууль бус худалдааны гэмт хэргийн талаарх хяналт-шинжилгээний ажлын хэсэг бий болох.

3. Олон нийтийн хяналтын сүлжээг чадавхжуулах, төсөл хэрэгжих цэгүүдэд гэмт хэргийн талаарх тагнуулын мэдээлэл олох боломжийг нэмэгдүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх.

“Олон нийтийн хяналтын сүлжээг чадавхжуулах, төсөл хэрэгжих цэгүүдэд гэмт хэргийн талаарх тагнуулын мэдээлэл олох боломжийг нэмэгдүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд төслийн зүгээс дараах гол гол үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ЛАСН нь Дорноговь аймгийн Эрдэнэцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн

Хуралтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Олон нийтийн таван цагдааг дүрэмт хувцас, бусад хэрэглэгдэхүүн, цалингаар хангаж ажиллан, зэрлэг амьтны хууль бус худалдаа, наймааны талаар ард иргэдийн дунд сурталчилгаа явуулж, зэрлэг амьтны хууль бус худалдаанд өртдөг зэрлэг амьтны эд эрхтэнийг таньж тодорхойлох, хүний эрх, хүйсийн тэгш байдлын талаар гурван удаагийн сургалт зохион байгуулсан байна.

- ЛАСН нь олон нийтийн хяналтын сүлжээг чадавхжуулах чиглэлээр зөвлөх ажиллуулж, олон нийтийн цагдаа нарт орон нутгийн иргэдтэй хэрхэн үр дүнтэй ажиллах талаар сургалт зохион байгуулж, гарын авлага боловсруулан олон нийтийн цагдаа нарт хүлээлгэн өгсөн.

- Олон нийтийн цагдаа нар ажлын төлөвлөгөө гаргаж ажиллан, улирал тутамын тайлангаа ЛАСН-т хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

- Олон нийтийн мэдлэг хандлагын судалгааг хийж, мэдлэг хандлагыг өөрчлөх зорилгоор тараах материалууд, гарын авлага боловсруулан холбогдох байгууллага, хүмүүст тараасан.

Олон нийтийн цагдаа нарыг чадвахжуулах сургалтын үр дүн

Монгол улсад Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн хэрэгжүүлж буй “Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн зүгээс улсын хил дагуу байрших гол гурван боомт болох Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Замын-Үүд болон Хатанбулаг сумын Ханги, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт хилийн боомт орчимд ажилладаг олон нийтийн цагдаа нарын чадавхийг сайжруулах зорилгоор цуврал сургалт зохион байгуулан олон нийтийн цагдаа нартай тус нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар хамтран ажиллаж байна.

Сургалтууд нь олон нийтийн цагдаа нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулахад чиглэгдэхээс гадна Монгол улсад хууль бус агнуур болон хууль бус худалдаанд өртөж буй ан амьтад, тэдгээрийн өнөөгийн нөхцөл байдал, хуулийн хэрэгжилт, илрүүлэлтийн талаар, хууль бус агнуур, худалдаанд өртөж буй хөхтөн амьтдыг таних тодорхойлох арга зүй, ард иргэдийн дунд хууль эрх зүйн сурталчилгаа хийх үр дүнтэй арга зүй, хүний эрх жендерийн асуудлуудалаар мэдлэг чадварыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна. Их Британийн Хил Хамгаалах Хүчний төлөөлөгчид сургалтын үеэр өөрсдийн ажлын туршлагаа хуваалцсаж санал солилцсон нь үр өгөөжтэй үйл ажиллагаа болсон байна.

Мөн олон нийтийн цагдаа нар орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх зорилгоор хамтын оролцооны арга зүйн сургалт, дадлага ажлуудыг хийсэн. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд оролцооны аргаар сумын хэмжээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудыг олон нийтийн цагдаа болон орон нутгийн шийдвэр гаргагчид нутгийн иргэдтэй хамтран тодорхойлсон байна. Зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдааг таслан зогсоход гааль, цагдаа, хил хамгаалах байгууллагууд нутгийн иргэдтэй хамтран “олон нийтийн хяналтын сүлжээг” бий болгох боломж, энэ талаарх олон улсын туршлага, олон нийтийн хяналтын сүлжээг байгуулах боломж нөхцлийн талаар хэлэлцэж, харилцан санал солилцсон байна.

Олон нийтийн цагдаа нар ажил үүргийнхээ дагуу иргэд, малчидтай харилцах, мэдээлэл цуглуулах оролцооны аргуудад суралцаж, ажлын төлөвлөгөө боловсруулан түүнийгээ төслийн зорилго, үйл ажиллагаатай уялдуулан сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, үйл ажиллагааны гүйцэтгэлийг холбогдох талуудад тайлагнан ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд ажиллаж буй олон нийтийн цагдаа Б. Оонондамдинтай хийсэн ярилцлага судалгааны хэсгээс:

“Төслөөс зохион байгуулсан сургалтуудад суусанаар ямар амьтныг худалдаалбал хууль бус гэж үзэх ёстойг сайн мэддэг болсон. Эхний сургалтын дараагаар эргүүл шалгалт хийж байгаад Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэр дээр тарвага, дорго, зээр, буга зэргийг ачаад явж байсан машинуудыг илрүүлсэн. Улаанбаатар хотод болсон CITES-н буюу “Зэрлэг амьтан баургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн” сургалтаар манай улсын ямар ямар зүйлийн амьтад хууль бус худалдаанаас хамгаалагдсан болохыг мэдэж авсан төдийгүй манай улсаар дамжин дэлхийд ховор ямар амьтны худалдаа хийгдэж, хил дамжин өнгөрөх боломжтой байдаг талаар анх удаагаа шинэ мэдээлэл сонссон. Энэ сургалтаар өмнөх сургалтаас сурсан зүйлүүдээ бас улам сайн баталгаажуулж, бататгаж мэдэж авсан.

Төслийн зүгээс манай Эрдэнэцагаан суманд оролцооны аргаар сургалт зохион байгуулсан явдал нь хамтран ажиллаж буй бүх талууд олон нийтийн цагдааг зэрлэг амьтны хууль бус агнуур болон хууль бус худалдааны зөрчлийг илрүүлэх талаар юу хийх ёстойг ойлгодог болж миний ажилд хамтын ажиллагааны нэлээд том ахиц гарсан. Засаг дарга, сумын захиргааны мэргэжилтэнүүд, байгаль хамгаалагч нар, ард иргэд надтай хамтран ажиллахдаа улам нээлттэй болсон. Миний ажилд хандах хүмүүсийн хандлага эрс сайжирсан. Иргэдийн хандлага эерэг болж сэжигтэй тохиолдлууд болох хаана ямар ан амьтны мах, арьс байгаа талаар мэдээлэл хэд хэдэн удаа ирж байсан. Эдгээр сургалтуудад сурсаны үр дүнд сумандаа 2019 онд нийт 4 зөрчил илрүүлсэний 2 нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой байсан. 2020 онд зэрлэг амьтны хууль бус агнууртай холбоотой 1 зөрчил илрүүлсэн. 2020 оны 1 сарын 15 наас одоо болтол хил хаагдсан болохоор зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой зөрчил илрүүлэх байдалд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл сэжигтэй зүйл бага байна.

Сүүлд мөн дахин Улаанбаатарт очиж 2 өдрийн сургалтанд сууж ажлын төлөвлөгөө гарган олон нийтэд

сурталчилгааг хэрхэн үр дүнтэй хийх ёстой талаар нэлээд сайн мэдлэгтэй болсон. Сумынхаа иргэдийн дунд нийгмийн сүлжээний платформ ажлуулж (Facebook group) сурталчилгаа хийх, мэдээлэл түгээх ажлуудаа Ковид цар тахлын хөл хорионы үеэр үргэлжлүүлэн хийж байна. 2021 оны 1 сарын байдлаар 100 гаруй хүн энэ платформд нэгдээд байна.

Зэрлэг амьтны тархац ихтэй хууль бус агнуур гарах эрсдэлтэй газруудын судалгааг хийсэн.

Дорноговь аймгийн Хатанбулаг суманд ажиллаж буй олон нийтийн цагдаа Б. Орхонцэцэгтэй хийсэн ярилцлага судалгааны хэсгээс:

“Би бусад олон нийтийн цагдаа нарыг бодвол сүүлд ажилд орсон. Ажилд орсныхоо дараахан буюу 2020 оны зун Улаанбаатар хотод ирж сургалтанд суусан. Энэ сургалтанд суусанаар би маш олон төрлийн хэрэгтэй мэдээлэл сонссон. Ялангуяа миний зүгээс зэрлэг ан амьтны хууль бус агнуур болон худалдааг бууруулах чиглэлээр юу хийх ёстойгоо сайн ойлгож авсан. Гэмт хэргээс ард иргэдийг хэрхэн сэргийлэх, хүний наймаа болон бусад эрсдлийн талаар мөн нэлээд сайн мэдлэгтэй болсон

Сургалтнаас ирээд сумынхаа байгаль хамгаалагчтайгаа хамтраад амьтны тооллого судалгаа хийдэг болсон. Манай сум орон нутагт ямар ямар зэрлэг амьтан амьдардаг болохыг хөдөөгүүр явж нүдээр үзлээ.

Мөн сургалтуудад суусанаар ажлын төлөвлөгөө боловсруулж ямар ажил хийх талаараа зорилго чиглэлтэй болсон төдийгүй сурсан зүйлээ бататган унших ном, гарын авлагатай болж ирсэн. Олон нийтэд сурталчилгаа явуулах оролцооны арга сурч ирсэн. Малчдын дунд ухуулга сурталчилгаа хийж, ном боршуур байнга тарааж байгаа. Мөн сумын төвийн айлуудаар явж л сурталчилгаа хийдэг. Ажлын төлөвлөгөөний маань биелэлт 60% тай байгаа..

Хилээр зөвхөн нүүрс, жонш гарахаас бусад бүх үй ажиллагаа Ковид цар тахал гарсантай холбоотой хаагдсан тул зэрлэг амьтны хууль бус худалдаатай холбоотой зөрчил манай боомтоор гарахгүй байгаа. ”



Тайлангын товч танилцуулга

ЛАСН-тай гэрээ байгуулан “Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн 3 дугаар зорилтын хүрээнд олон улсын туршлагауудыг эмхтгэн дүгнэх, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон олон нийтийн цагдаа нарт зориулан зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулахын тулд орон нутгийн ард иргэдтэй хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах талаарх зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тус тайланд дээрх ажлын эцсийн үр дүнгийн талаар тусгасан.

Энэ тайлан нь Ерөнхий хэсэг, Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллаж буй олон улсын туршлага, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмж гэсэн 3 үндсэн бүлэгтэй бөгөөд Дүгнэлт, Ном зүйг багтаасан болно.

Монгол улсад зэрлэг амьтны хууль бус худалдаа наймаа нь 1990 оноос хойш буюу нийгмийн шилжилтийн үеэс эрчимтэй нэмэгдсэн. Том хөхтөн амьтад болох халиун буга (*Cervus elaphus*), аргаль хонь (*Ovis ammon*), цагаан зээр (*Procapra gutturosa*), хүдэр (*Moschus moschiferus*), Монгол бөхөн (*Saiga tatarica*), жижиг хөхтөн амьтадаас Монгол тарвага (*Marmota sibirica*) зэрэг амьтад (3) зэрлэг амьтны хууль бус худалдааны золиос болж тоо толгой нь нэлээд буурч зарим амьтадын популяци устгах эрсдэлд өртсөн байна. Тухайлбал, халиун буганы популяцийн тоо толгой 92% -иар 1990 ээс 2004 оны хооронд буурсан байна (20). Монгол тарваганы популяцийн хэмжээ 75 %-иар буурч 15 сая бодгалиар 1990-ээс 2001 оны хооронд хорогджээ (2). Ийнхүү биологийн олон янз байдлын доройтол нь экосистемийн төлөв байдал, хүний сайн сайхан байдалд ч сөрөг нөлөө үзүүлж байна.

Энэхүү төсөл нь зэрлэг амьтны хууль бус худалдааг зогсооход чухал үүрэг гүйцэтгэдэг хуулийн хэрэгжилтийг сайжруулах чадавхийг

нэмэгдүүлэхийг зорьж байгаа явдал нь зэрлэг амьтадын популяцид дарамт учруулж буй хулгайн агнуурыг бууруулах дам нөлөөтэй юм. Төсөл хэрэгжиж буй хилийн боомтуудад цагдаагийн ажилтан болон орон нутгийн ард иргэдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулж улмаар нутгийн иргэдэд түшиглэсэн мэдээллийн сүлжээг байгуулахыг зорьж байгаа төдийгүй орон нутгийн иргэдэд зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар сурталчилгаа явуулан ажиллаж байгаа явдал нь зэрлэг амьтны хууль бус худалдааг шуурхай илрүүлэх ач холбогдолтой төдийгүй орон нутгийн иргэдийг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Энэ төслийн хүрээнд орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж мэдээллийн сүлжээг байгуулах талаар олон улсын туршлагауудыг судлах нь улс орнуудын ололт амжилтаас суралцан өөрийн орны онцлогт тохирсон загварыг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Олон улсын туршлагауудын ололттой талууд, өөрийн орны хууль эрх зүйн орчин, нийгэм, соёл, эдийн засгийн онцлогийг харгалзан үзэж төсөл хэрэгжиж буй сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон олон нийтийн цагдаа нарт зориулсан зөвлөмж боловсруулах явдал нь тэдний ажлын үр дүнг сайжруулахад чухал түлхэц болно гэж найдаж байна.

Үндэслэл



© Д. Лхагвасүрэн

Монгол улсад зэрлэг амьтны хууль бус худалдаа наймаа нь 1990 оноос хойш буюу нийгмийн шилжилтийн үеэс эрчимтэй нэмэгдсэн. Том хөхтөн амьтад болох халиун буга (*Cervus elaphus*), аргаль хонь (*Ovis ammon*), цагаан зээр (*Procapra gutturosa*), хүдэр (*Moschus moschiferus*), Монгол бөхөн (*Saiga tatarica*), жижиг хөхтөн амьтадаас Монгол тарвага (*Marmota sibirica*) зэрэг амьтад (3) зэрлэг амьтны хууль бус худалдааны золиос болж тоо толгой нь нэлээд буурч зарим амьтадын популяци устгах эрсдэлд өртсөн байна. Тухайлбал, халиун буганы популяцийн тоо толгой 92% -иар 1990 ээс 2004 оны хооронд буурсан байна (20). Монгол тарваганы популяцийн хэмжээ 75 %-иар буурч 15 сая бодгалиар 1990-ээс 2001 оны хооронд хорогджээ (2). Ийнхүү биологийн олон янз байдлын доройтол нь экосистемийн төлөв байдал, хүний сайн сайхан байдалд ч сөрөг нөлөө үзүүлж байна.

Энэхүү төсөл нь зэрлэг амьтны хууль бус худалдааг зогсооход чухал үүрэг гүйцэтгэдэг хуулийн хэрэгжилтийг сайжруулах чадавхийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа явдал нь зэрлэг амьтадын популяцид дарамт учруулж буй хулгайн агнуурыг бууруулах дам нөлөөтэй юм. Төсөл хэрэгжиж буй хилийн боомтуудад цагдаагийн ажилтан болон орон нутгийн ард иргэдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулж улмаар нутгийн иргэдэд түшиглэсэн мэдээллийн сүлжээг байгуулахыг зорьж байгаа төдийгүй орон нутгийн иргэдэд зэрлэг амьтны

хууль бус худалдааны талаар сурталчилгаа явуулан ажиллаж байгаа явдал нь зэрлэг амьтны хууль бус худалдааг шуурхай илрүүлэх ач холбогдолтой төдийгүй орон нутгийн иргэдийг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Энэ төслийн хүрээнд орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж мэдээллийн сүлжээг байгуулах талаар олон улсын туршлагуудыг судлах нь улс орнуудын ололт амжилтаас суралцан өөрийн орны онцлогт тохирсон загварыг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Олон улсын туршлагуудын ололттой талууд, өөрийн орны хууль эрх зүйн орчин, нийгэм, соёл, эдийн засгийн онцлогийг харгалзан үзэж төсөл хэрэгжиж буй сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон олон нийтийн цагдаа нарт зориулсан зөвлөмж боловсруулах явдал нь тэдний ажлын үр дүнг сайжруулахад чухал түлхэц болно гэж найдаж байна.





Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх талаарх олон улсын туршлага



© Torran Murray

Зэрлэг амьтны хууль бус агнуур болон хууль бус худалдаа нь олон улсын хэмжээнд бар, хирс, заан гэх мэт устах аюулд өртсөн зүйлүүдийн популяцийн тоо толгойг бууруулж байгаа төдийгүй элбэг тархацтай зүйлүүдийн ч тоо толгойг цөөрүүлж буй шалтгаан болж байгаа тул олон улсын байгаль хамгааллын

анхаарлыг татаж буй нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудал болдог байна.

Манай улсын хувьд ч мөн адил буга, бөхөн, ирвэс, аргаль, хүдэр, тарвага зэрэг хөхтөн амьтад нь хууль бус агнуур болон хууль бус худалдааны золиос болж тоо толгой нь буурч устгах эрсдэлд өртөж байна. Тухайлбал, Монгол бөхөнгийн (*Saiga tatarica*) популяцийн тоо, толгой 1999 оноос 2004 оны хооронд эврийг нь хил дамнуулан хууль бусаар худалдаалах сэдлээр хулгайн агнуурт өртөн 85 % буурсан байна (11). Мөн Монгол тарваганы популяцийн тоо толгой тогтворгүй агнуур болон эд эрхтэн, арьсыг нь хил дамнуулан хууль бусаар худалдаалах болсонтой холбогдуулан 1990 оноос 2001 оны хооронд 75 % буурсан байна (3).

Дан ганц хуулийн хэрэгжилтийг сайжруулах арга замаар зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх нь хангалтгүй гэдгийг дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрч байна. Зэрлэг амьтны хууль бус худалдаанд нийгмийн янз бүрийн бүлгүүд оролцдог нарийн нийлмэл процесс учраас олон талт стратеги, олон талт шийдлүүд, олон төрлийн арга замаар тэмцэх нь илүү үр дүнтэй болох нь улс орнуудын туршлагаас харагдаж байна.

Олон улсын хэмжээнд зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд дараах үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- нэгдсэн бодлогоор хангах,

- зэрлэг амьтны эд эрхтэнийг хэрэглэгч талын эрэлтийг бууруулах,
- хуулийн хэрэгжилтийг сайжруулах,
- хууль бус үйлдлийг илрүүлэх ажиллагаанд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх стратеги боловсруулж, баримтлан ажиллаж байна (21).

Нэгдсэн бодлогоор хангах

Олон улсын туршлагаас харахад үндэсний хэмжээнд зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх талаарх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг бие даасан бодлого боловсруулан ажиллах нь зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа болон түүний уялдааг сайжруулахад түлхэц болдог төдийгүй зэрлэг амьтны хууль бус худалдааны нарийн төвөгтэй харилцааны талаар олон талаас нь судлах, суурь мэдээлэл цуглуулах, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад

учирч болох бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд чухал үр дүнгээ өгдөг байна.

Үндэсний хэмжээний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласнаар стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд шат шатанд хяналт тавьж ажиллах механизм бий болдог байна. Мөн хуулийн хэрэгжилтэнд үе шаттайгаар хяналт үнэлгээ өгөх, ололт болон алдаагаа үнэлж, суралцах, үйл ажиллагаагаа уян хатан явуулахад үр дүнтэй түлхэц болдог байна.

Зарим улс орнууд зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх талаарх үндэсний хэмжээний бие даасан бодлого болон стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласнаар тодорхой

үр дүн хүрсэн байна. Тухайлбал, 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Америкийн Нэгдсэн Улсын Обамагийн засгийн газраас “Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх үндэсний стратеги төлөвлөгөө”-г боловсруулан баталжээ. Энэхүү стратеги төлөвлөгөөнд нэн тэргүүнд анхаарал хандуулан ажиллах чиглэлийг тодорхойлсон бөгөөд тус чиглэлд хуулийн хэрэгжилтийг сайжруулах, зэрлэг амьтны эд эрхтэн, түүхий эдийн эрэлтийг бууруулах, олон улсын болон дотоод хамтын ажиллагааг



© Д. Лхагвасүрэн

сайжруулах асуудлуудыг тус тус багтааж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна (13).

Зэрлэг амьтны эд эрхтэнийг хэрэглэгч талын эрэлтийг бууруулах

Зэрлэг амьтны эд эрхтэнг худалдан авах эрэлт байгаа цагт хууль бус агнуур явагдах гарцаагүй нөхцөл үүсдэг тул эрэлтийг бууруулах арга хэмжээ авахад Зүүн-өмнөд Азийн орнуудад ихээхэн анхаардаг болсон байна. Эрэлтийг бууруулахад хил дамнасан хамтын ажиллагааг өрнүүлэх ажлыг хийх нь зайлшгүй чухал арга хэмжээний нэг юм.

Эрэлтийг бууруулахад хэрэглэгчдийн дадлыг өөрчлөх, зэрлэг амьтны эд эрхтэнг хэрэглэх хэрэглээг өөр бүтээгдэхүүнээр орлуулах, илүү сайн бүтээгдэхүүнээр хангах, хууль бус үйлдлийн эрсдэл үр дагаврыг олон нийтэд ойлгуулах зэрэг арга хэмжээ багтдаг байна.

Олон улсад ёс суртахууны өндөр стандартыг хангасан хувцас, эм, хүнсийг нийгэмд сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Ёс суртахууны өндөр стандартыг хангасан бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх нь нийгэмд эзлэж буй байр суурь, үнэт зүйлийн бэлэг тэмдэг болно гэсэн чиглэлээр сурталчилгаа хийж ажиллаж байна. Энэ сурталчилгаанд олны танил, нийгмийн элит бүлгүүдийг оролцуулах нь үр дүнгээ өгч байна.

Мөн түүнчлэн хууль бус агнуур, хууль бус

худалдааны шалтгаануудыг судлах, мэдээллээр хангах сурталчилгааны кампанит ажлуудыг зохион байгуулж байна.

Хуулийн хэрэгжилтийг сайжруулах

Хуулийн хэрэгжилтийг хангахад цагдаа, хил хамгаалах байгууллага, гааль, байгаль хамгаалагч, улсын байцаагч нар хууль бус үйлдлийг илрүүлэхэд чухал үүрэгтэй ажилладаг. Шүүх, прокурорын байгууллага нь хууль бус үйлдэл хийсэн этгээдэд хуулийн дагуу зохих шийтгэлийг оногдуулах ажлыг хийдэг.

Хуулийн хэрэгжилтийг сайжруулахад мэргэжилтүүдийн чадавхийг сайжруулах, ухаалаг технологийг нэвтрүүлэх, бүх талын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлж байна.

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллах

Зэрлэг амьтадын хууль бус худалдаатай тэмцэхэд нутгийн ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь үр дүнтэй арга замуудын нэг мөн гэдгийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хэдий ч яаж, хэрхэн ард иргэдтэй хамтран ажиллаж байж үр дүнд хүрэх нь тухайн улсын соёл, экологи, нийгэм, эдийн засаг, улс төрийн онцлогуудаас мөн тухайн орон нутгийн нөхцөл байдлаас, ямар хөшүүргүүдийг хэрэглэж байгаагаас, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч талуудын ур чадвар зэрэг маш олон хүчин зүйлээс хамаарч байна. Улс орон бүрийн экологи, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдал өөр хоорондоо ялгаатай тул бусад улс орны туршлагаас суралцаж, өөрийн улс орныхоо онцлогт тохирсон арга замыг ухаалгаар боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх арга замууд

Олон улсын туршлагаас харахад нутгийн иргэдтэй хамтран зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх түгээмэл дөрвөн үндсэн арга замыг олон улсын хэмжээнд хэрэгжүүлж байна (8). Үүнд:

1. Хууль бус үйлдлийн эсрэг сөрөг хөшүүргийг бий болгох. Энэ арга зам нь зэрлэг амьтдыг хууль бусаар худалдаалах нь өртөг өндөртэй, эрсдэл ихтэй, хэцүү байх нөхцлийг

бүрдүүлэхэд чиглэгддэг. Энэ арга замын хүрээнд улс орнууд хуулийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарч, хуулийн хэрэгжилтийг хангагч талууд болон нутгийн иргэдэд түшиглэсэн хулгайн агнуурыг бууруулах зорилготой эргүүл болон мэдээллийн сүлжээг байгуулан ажиллаж байна.

2. Зэрлэг амьтдыг хамгаалах эерэг хөшүүргийг бий болгох. Энэ арга зам нь зэрлэг амьтадыг хамгаалсанаар мөн зэрлэг амьтны тогтвортой менежментийн үйл ажиллагаанд оролцсоноор нутгийн иргэд мөнгөн ба мөнгөн бус үр өгөөж хүртдэг байх хөшүүргүүдийг бий болгоход чиглэгддэг. Энэхүү арга замын хүрээнд нутгийн иргэд зэрлэг амьтадыг хамгаалсанаар амьжиргаанд нь чухал ач холбогдолтой мөнгөн ба мөнгөн бус үр өгөөж хүртдэг тул зэрлэг амьтад бол бидний чухал үнэ цэнэтэй нөөц баялаг мөн юм байна гэдгийг бүрэн ухамсарласны үндсэн дээр хулгайн агнуур, хууль бус худалдааг гаргуулахгүй байхын төлөө хууль хэрэгжүүлэгч талтай хамтран ажиллах нөхцөл бүрддэг байна.



© Torran Murray

3. Зэрлэг амьтадтай зэрэгцэн амьдрахад гардаг өртөгийг багасгах. Энэ нь зэрлэг амьтан хүмүүсийн хоорондын зөрчлийг бууруулахад чиглэгддэг. Энэ арга замын хүрээнд нутгийн иргэдийн мал аж ахуй, газар тариаланг болон бусад өмч хөрөнгийг зэрлэг амьтанаас хамгаалах хашаа барих, нөхөн олговор олгох, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд чиглэгддэг. Нутгийн иргэд зэрлэг амьтадтай зөрчилтэй амьдардагийн улмаас хулгайн агнуур хийх, хууль бусаар зэрлэг амьтны эд эрхтэнийг худалдаалах нь багасдаг байна.

4. Амьжиргааны олон эх үүсвэрүүдийг дэмжих. Энэ нь эдийн засгийн боломжуудыг бий болгох болон амьжиргааны болон орлогын олон эх үүсвэрүүдийг бий болгоход чиглэгддэг. Энэхүү арга замын хүрээнд нутгийн иргэдийг зэрлэг амьтны худалдаа наймаанаас хамааралгүйгээр аж амьдралаа авч явах чадавхи болон боломжуудаар хангагдахад анхаардаг. Нутгийн иргэд амьжиргааны олон янзын эх

үүсвэртэй болоход нь туслах үйл ажиллагаа багтдаг. Тухайлбал, агро-ойн аж ахуй эрхлэх, зөгийн аж ахуй эрхлэх, жижиг бизнес эрхлэх зэргээр зэрлэг амьтны худалдаа наймаанаас хамааралгүйгээр амьдрах боломжтой болдог байна.

Байгаль Орчин ба Хөгжлийн Төлөөх Олон Улсын Хүрээлэнгийн судлаач Дилис Рое болон Франческа Боокер нар 2018 онд нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй янз бүрийн орны тавин өөр туршлагаудад үнэлгээ хийсэн байна. Эдгээр өөр өөр орны туршлагаас харахад



© Ж. Жаргал



© Ж. Жаргал

хамгийн түгээмэл хэрэглэгдэж байсан нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллах арга зам бол “зэрлэг амьтныг хамгаалах эерэг хөшүүргийг бий болгох” явдал байсан.

Зарим улс орнууд зэрлэг амьтныг хамгаалах үйл ажиллагаанаас нутгийн иргэд тодорхой өгөөж хүртдэг хөшүүргүүдийг бий болгож чадсан байна. Тухайлбал, зэрлэг амьтанд түшиглэсэн аялал жуулчлалаас нутгийн иргэд ажлын байраар хангагдаж цалинждаг, мөн тэдгээр аялал жуулчлалаас олсон орлогоос орон нутгийн эмнэлгийн үйл ажиллагаа, сургууль, олон нийтийн соёлын арга хэмжээг санхүүжүүлдэг, зам болон харилцаа холбоо зэрэг бусад дэд бүтцийг бий болгосон байна.

Тухайн орон нутагт хууль бус агнуур болон худалдаа явагдах нь нутгийн иргэдийн аюулгүй байдалд төдийгүй жуулчдын аюулгүй байдалд, аялал жуулчлалын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тул хулгайн агнуур хууль бус худалдаа гаргуулахгүй байхын төлөө нутгийн иргэд эргүүл

хийх, сэжигтэй үйлдлийн талаар мэдээлэл өгдөг тогтолцоог бий болгож чаджээ.

Мөн зарим орны туршлагаас харахад зэрлэг амьтны хулгайн агнуур болон хууль бус худалдааг нутгийн иргэд хариуцсан газар нутаг дээрээ гаргуулахгүй гэж холбогдох байгууллагатай гэрээ хийж гэрээний биелэлт хангагдсан нөхцөлд урамшуулал авах, нийгмийн тустай асуудлуудаа шийдвэрлэх

буцалтгүй тусламж авах, гар урлалын бүтээгдэхүүн борлуулах зэргээр тодорхой хэмжээний урамшуулал авдаг байна.

Дараагийн түгээмэл арга зам бол хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нутгийн



© Torran Murray

иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Нутгийн иргэд тодорхой хэмжээний цалин урамшуулал авч эргүүл хийдэг тогтолцоог бий болгосон төдийгүй, хууль бус үйлдэл, сэжигтэй тохиолдлын талаар цаг алдалгүй мэдээлэл өгсөнөөр урамшуулал авдаг байна.

Улс орнууд хууль бус агнуураас хамааралтай амьдардаг ард иргэдийн дунд амьжиргааны олон эх үүсвэрийг бий болгох чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна. Хулгайн агнуур хийдэг хүмүүсийг жижиг бизнес эрхэлдэг болгох, органик тариалан эрхлүүлэх, мөөгний аж ахуй, зөгийн аж ахуй, агро-ойн аж ахуй эрхлэхэд нь чадавхжуулах, эхлэлийн санхүүжилтыг босгоход нь тусламж үзүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Харин үнэлгээ хийсэн нийт тавин туршлагын найм нь зэрлэг амьтан хүн хоорондын зөрчлийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авчээ. Тухайлбал, газар тариаланг заанаас хамгаалсан хашаа барих, хирс болон бусад зэрлэг амьтан идэх дургүй тариалан эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Үнэлгээ хийсэн бүхий л орны туршлагаас харахад зэрлэг амьтны хамгаалах ач холбогдол үнэ цэнийг ойлгох, хууль бус агнуур хийх, худалдаа хийхээс учирч болох сөрөг үр дагаврыг ойлгох, мөн хуулийн талаарх сурталчилгаа, сургалтыг ард иргэдийн дунд явуулахад анхаарч ажиллахыг чухалчилж байна (7).





IBBI LLC

Зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах чиглэлээр нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй олон улсын туршлага



Бид нийт 40 гаруй орны туршлагуудыг судалж үзээд, дараах долоон орны туршлагыг манай орны хувьд суралцаж болохуйц

туршлага гэж үзсэний үр дүнд дараах орнуудын туршлагуудыг эмхтгэн дүгнэв.

Мексик улсын Яакатанд (Yucatan) “далайн өргөст хэмх” хэмээх амьтны хууль бус худалдааг илрүүлэхэд нутгийн иргэдтэй хамтран ажиллаж буй туршлага

Зах зээлийн эрэлт өндөр байдгийн улмаас далайн өргөст хэмхийн ихэнх зүйлүүд устгах аюулд өртсөн байна. Хятадын тансаг зэрэглэлийн хоолонд энэ амьтныг хэрэглэдэг бөгөөд хатаасан 450 гр далайн өргөст хэмх 1100 америк доллар хүрдэг. Мексикээс Азийн зах зээлд гарахдаа Америкын Нэгдсэн Улсаар дамжин өнгөрдөг. 2018 онд нэгэн аав хүү хоёрын бүлэг хүмүүс 17 сая америк доллартай тэнцэх далайн өргөст хэмхийн захиалга өгсөн байсан нь батлагджээ. Далайн өргөст хэмх нь удаан хөдөлгөөнтэй мөн өсөлт удаантай, далайн ёроолд амьдардаг амьтан бөгөөд хууль бус агнуурын улмаас популяцийн тоо толгой эрс буурч устгах аюулд өрсөнөөс гадна хууль бус үйлдэл нь нутгийн иргэдийн амьжиргаа болон аюулгүй байдалд сөрөг нөлөөлөлтэй байсан байна.

2020 оны нэгдүгээр сараас Яакатаны ард иргэд АНУ-ын Загас Зэрлэг Амьтныг Хамгаалах Албаны Олон улсын байгаль хамгааллын хэлтэс, Хуулийн хэрэгжилтийн нэгж, Мичиганий Их Сургуулийн Латин Америк Кариб Судлалын судлаачидтай хамтран ажиллаж “орон нутгийн иргэдэд түшиглэсэн мэдээллийн сүлжээг” байгуулжээ. Энэ сүлжээнд загасчдын хоршоодын гишүүд хамрагдсан байна. Гишүүд удаа дараа хамтын оролцоог

хангасан сургалтуудад хамрагдаж хулгайн агнуур хийдэг гол гол газрууд, далайн өргөст хэмхийг боловсруулдаг, зөөвөрлөж тээвэрлэдэг газруудын зураглалыг гаргажээ.

Тэдний орон нутгийн нөөц баялаг хомсдож байгаад санаа тавьж хууль бус үйлдлийг илрүүлэхэд мэдээллээр хангах чиглэлээр ажиллахыг зөвшөөрч ажиллаж байна.

Мөн хууль бус үйлдлийн талаар мэдээлэл авах утас ажиллуулж, хэрхэн яаж мэдээлэл өгөх талаар тараах материал тарааж, мэйл хаяг ажиллуулж, радио нэвтрүүлэг, подкаст хийж байна (17).

Энэ туршлагаас харахад орон нутгийн иргэдэд түшиглэсэн мэдээллийн сүлжээг амжилттай байгуулж эхлэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд:

1. Хамтран ажиллах зорилтот бүлгийг зөв тодорхойлж чадсан байна. Загасчидын амьжиргааны гол эх үүсвэр болох тогтвортой

ашиглаж ирсэн нөөц баялагт хулгайн агнуур, хууль бус худалдаа нь сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд энэ нөөц баялаг тэдэнд үнэ цэнэтэй байдаг тул хуулийн хэрэгжилтийг хангагч талуудтай хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил төрсөн байна.

2. Хамтран ажиллах зорилтот бүлгийн ард иргэдийг чадавхжуулсан байна. Удаа дараа хамтын оролцооны аргаар сургалтуудыг зохион байгуулсаны үр дүнд орон нутгийн иргэд хууль бус худалдаатай тэмцэх нь тэдэнд ямар ач холбогдолтойг зураглаж ойлгох нөхцөл бүрдсэн байна.

3. Оролцооны аргыг ашиглан ард иргэдийг хэрхэн идэвхжүүлэх чиглэлээр

мэргэшсэн нийгмийн шинжлэх ухааны судлаачидтай хамтран ажилласан нь богино хугацаанд үр дүнтэй хамтын ажиллагааг эхлүүлэхэд нөлөөлсөн байна.

Намиби улсад 1993
оноос одоог хүртэл
хэрэгжижүүлж буй
туршлага

Намиби улсад заан, хирс зэрэг амьтдын хулгайн агнуур хууль бус худалдаа 1993 оноос хойш буурч эдгээр амьтдын тоо толгой өсөж байна.

© Torran Murray



1993 онд Дэлхийн Байгаль Хамгаалах Сангаар дамжуулан АНУ-ын Засгийн газрын тусламжийн байгууллага нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллыг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах үйл ажиллагаанд томоохон санхүүжилт олгосон байна. 1996 онд Намиби улсад нийтийн эзэмшлийн газар нутгуудад нутгийн иргэд байгаль хамгаалах байгууллага байгуулахыг дэмжсэн ба тэдний хариуцдаг газар нутагт тропи агнуурын байгууллагууд болон эко-аялал жуулчлалын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдэнтэй гэрээ хийх хууль эрх зүйн нөхцөлөөр хангаж эхэлсэн байна.

2014 он гэхэд нийт 300,000 хүн 79 нутгийн иргэдийн байгууллагад харъяалагдан 10 сая га газрыг нутгийн иргэдийн хамгаалалтанд оруулсан байна. Орон нутгийн ард иргэд цагдаа болон бусад хууль хяналтын байгууллагуудтай



© Torran Murray

© Torran Murray



хамтран зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдаа наймааны эсрэг нүд, чих болон хамтран ажиллаж чадсаны үр дүнд хуулийн хэрэгжилт сайжирсан байна. Үүний үр дүнд Намиби улсад зэрлэг амьтны тоо толгой элбэгшиж чаджээ (18). Гэхдээ олон улсын санхүүгийн болон захиргааны тусламж дэмжлэг зогсоход орон нутгийн иргэдийн байгууллагууд бие даан амьжилттай үргэлжлүүлэн ажиллахад бэлэн байгаа эсэх нь олон улсын шинжээчдийн эргэлзээг төрүүлдэг байна (1).

Намиби улсын туршлагын амжилтанд хүрсэн шалтгаануудыг дараах



© Enock Senteu

байдлаар дүгнэв. Үүнд:

- Нутгийн иргэдийг зохион байгууллалтанд оруулж чадавхжуулсан,
- Олон жилийн хамтын ажиллагаа, итгэлцлийг бий болгож чадсан,
- Зэрлэг амьтны хамгааллаас ард иргэд бодит үр өгөөж хүртэх хууль эрх зүйн таатай нөхцөл болон хөшүүргийг бий болгосон учраас нутгийн иргэд хуулийн

хэрэгжилтийг хангах талуудтай хамтран ажиллаж хууль бус үйлдлүүдийн талаар мэдээлэл өгдөг болсон байна.

Кени улсын хойд бэлчээр нутгийн туршлага

Кени улсын хойд нутгуудаар хуулийн хэрэгжилт сул,

овгуудын хоорондын зөрчил ихтэй, ард иргэдийн аюулгүй байдал хангагдаагүй байдалтай байсан тул нутгийн иргэдийн байгаль хамгааллын байгууллагууд байгуулагдаж эхэлсэн.

2013 онд Зэрлэг Амьтны Хамгаалал болон Менежментийн хуулинд өөрчлөлт орж, нутгийн иргэдийн байгууллагуудын үйл ажиллагааг хуулиар хүлээн зөвшөөрчээ.

Хулгайн агнуур, зэрлэг амьтны хууль бус худалдаа наймаатай тэмцэхийн тулд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажилласан байна. Нутгийн иргэдийн байгууллагын гишүүд хууль бус үйлдлийн талаар мэдээлэл өгдөг болж, мөн зэрлэг амьтны тоо толгой

болон бусад судалгааны мониторингийн ажилд идэвхтэй оролцдог болсон байна.

“Хойд бэлчээр нутгийн итгэлцэл” нэртэй байгууллага нь нутгийн иргэдийн байгууллагуудыг чиглүүлж, чадавхжуулж, тэднийг үндэсний засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллага нь дэмжиж ажилласан байна.

Заан болон бусад зэрлэг амьтдын гол амьдрах орчин

© Б. Ганхуяг



болсон 2.5 сая га газрыг нутгийн иргэдийн байгууллагууд хараа хяналтандаа авч ажиллаж байна. 2012 онд 101 заан хулгайн агнуурт өртсөн болохыг нутгийн иргэдийн байгууллагын гишүүд илрүүлж байсан бол 2014 онд нийт 27 зааны хулгайн агнуур тэдний хариуцсан газарт гарч хулгайн агнуур эрс буурсан байна (18).

Кени улсын шижээнээс бид дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

- Хууль эрх зүйн тааламжтай орчныг бүрдүүлж чадсан,
- Нутгийн иргэдийг чадавхижуулах ажлыг хийж, урт хугацааны хамтын ажиллагааг үүсгэж чадсан.
- Нутгийн иргэд байгаль хамгаалал, зэрлэг амьтны хамгаалалд оролцох үйл ажиллагаанаас үр өгөөж хүртдэг болсон.

Өмнөд Африкийн “Хар Мамбанууд нэртэй хулгайн агнуур болон зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх нэгж”-ийн туршлага

Хар Мамба нэртэй орон нутгийн санаачлага нь НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Эх Дэлхийн Шагналын эзэд болжээ. Өмнөд Африкийн Балуге Байгалийн Нөөц Газрын ахлах байгаль хамгаалагч Грег Спенсер байгалийн нөөц газрын орчимд амьдардаг ард иргэдтэй хамтран ажиллах энэхүү санаачлагыг

эхлүүлсэн байна.

Энэ нэгжийн гишүүд нь байгалийн өнгө дагуу дүрэмт хувцас өмсдөг бөгөөд сэжиг бүхий машин техник, хүмүүс, үйл ажиллагааг мэдээлдэг үндсэн үүрэгтэй. Энэ нэгжийн багийн гишүүдийн ихэнх нь эмэгтэйчүүд байна. Тэд ард иргэдийнхээ дунд хирс зэрэг ховор амьтдыг хамгаалах нь хулгай агнуур хийхээс илүү үр өгөөжтэй болох талаар сурталчилгаа, сургалтыг зохион байгуулдаг, эргүүл хийдэг байна.

Хар Мамбанууд нь хулгайн агнуурыг тэг болгох зорилготой ажиллаж байгаа бөгөөд хулгайн анчдын хэд хэдэн отог, ангийн махаар хоол хийдэг хоолны гал тогоог илрүүлж, урхи тавих болон хор тавих ажиллагааг багасгасан байна. Тэдний үйл ажиллагааг Өмнөд Африкийн засгийн газрын Олон Нийттэй Харилцах Хөтөлбөрөөс тодорхой хэмжээгээр санхүүжилэхээс гадна байгалийн нөөц газрын захиргаа зарим үйл ажиллагааг нь санхүүжүүлдэг. Тэд мөн хандиваар санхүүждэг байна. Энэ нэгжийн гишүүд



© Tintswalo Shipalana

урамшуулал, цалин авдаг байна. (1).

Өмнөд Африкийн Хар Мамба нарын туршлагаас харахад тэдний амжилтыг дараах байдлаар дүгнэн тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Зэрлэг амьтны хулгайн агнуур болон хууль бус худалдааг илрүүлэх орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгэм байгуулсан нь эмэгтэйчүүдийг чадавжин, цалинжих, мөнгөн урамшуулал авах зэрэг нь тодорхой үр өгөөжийг бий болгосон байна.
- Орон нутгийн иргэд нь өөрсдөө сургалт, сурталчилгааг ард иргэдийн дунд хийх нь илүү үр дүнтэй байсан байна.
- Эдгээр эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах найдвартай ар тал байсан нь тэдэнд учирч болох эрсдлийг багасгахад нөлөөлсөн.



© Jeffrey Barbee

Хойд Конго-Браззавил нутгийн уугуул иргэд Мбэнджеличүүдтэй хамтран ажилласан Конго улсын туршлага

Конго улсын хойд Конго-Браззавил нутгийн ойн уугуул иргэд болох Мбэнджеличүүд нь хагас нүүдэлчин аж амьдралтай, бичиг үсэггүй, зам харилцаа дэд бүтэц хөгжөөгүй ширэнгэн ойд амьдардаг байна. Тэд ойн баялагаас бүрэн хамааралтай амьдарч ирсэн бөгөөд хулгайн анчид тэдний газар нутагт нэвтрэн агнуурыг хайр гамгүй хийж байгаа нь тэдний амьжиргааны эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй тэдний аюулгүй тайван амьдралд ч аюул учруулах болжээ.

Тэд Лондонгийн Их Сургуулийн (University College London) “Иргэний Шинжлэх Ухаан” (Extreme Citizen Science) нэртэй судалгааны багийнхантай хамтран ажиллаж хууль сахиулах байгууллагын холбогдох хүмүүсд зэрлэг амьтны хууль бус агнуур болон хууль бус худалдаатай холбоотой мэдээллийг цаг алдалгүй мэдээллэдэг сүлжээг байгуулжээ.

Ийнхүү мэдээлэл өгөх нь тэд өөрсдийнхөө нөөц баялгийг гадны хулгайн анчдаас хамгаалах, өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах, байгаль хамгаалагч нар тэдэнтэй зүй бусаар харьцдаг байсантай тэмцэж буй хөшүүрэг болсон байна.

Лондонгийн Их Сургуулийн багийнхан тэдэнд зориулж техник хангамж, программ хангамж зохиож, хялбар ашиглах боломжтой GPS (байрлал тогтоох багаж) суурилуулсан гар утаснуудыг хэрхэн ашиглахыг зааж, мэдээллээ

хэрхэн дамжуулахыг сургасан байна. Мбэнджилчүүд хууль бус үйлдлийг мэдээлж байгаад хууль зөрчигч этгээдүүдэд баригдах нь эрсдэлтэй гэдгээ сайн мэдэж байлаа.

Конго улс нь үндэстэн дамнасан компаниудад газрын тос, эрдэс баялаг, мод нийлүүлж эдийн засгаа бүрдүүлдэг тул мод бэлтгэлийн замууд ойд бий болох явдал нь Мбэнжилчүүдийн амар тайван аж амьдралыг эрсдэлд оруулж байсан байна. Мөн хээл хахууль ихтэй, суурин газрын элит хүмүүс хулгайн анчидтай холбоо сүлбээтэй төдийгүй хулгайн анчид байгаль хамгаалагчдыг архидуулж, хахуульддаг тул хууль бус

© Torran Murray



агнуур болон худалдаа наймааг илрүүлэхэд төвөгтэй байдалтай байв.

Хууль бус агнуур нь ойн нөөц баялгийг тогтворгүй ашиглаж хомсдуулж улмаар Мбэнджилчүүдийн аж амьдрал аюулд өртөж байсан байна. Ойд хаа сайгүй урхи, хавх байрлуулсан нь эмэгтэйчүүд, хүүхдүүд хавханд өртөн бэртэж гэмтэх аюул нүүрлэсэн байна. Хулгайн анчид Калашников буугаар зэвсэглэсэн байдаг тул уугуул иргэдэд мөн аюул учруулах магадлал өндөр байдаг. 2010 онд Мбэнджил хүмүүс Лондонгийн Их Сургуулийн судлаачидтай хамтран ажиллаж нөөц баялгийн зураглал гаргасан бөгөөд судлаачид тэдэнд зориулж хууль бус этгээдүүд, сэжигтэй ул мөрийг тэмдэглэж авдаг программ боловсруулах ажлыг хийж, программ хангамжийг турших ажлыг амжилттай гүйцэтгэж, тэднийг сургаж мэдээлэл цуглуулж эхлээд байна.

Мбэнджилчүүд ямар нэгэн албан боловсролд хамрагдаж байгаагүй, овогийнхоо хэлээр ярьдаг, тэдний амьдарч буй орчинд цахилгааны эх үүсвэр байхгүй, 90%-н чийгшилтэй байдаг зэрэг олон саад бэрхшээлийг шийдвэрлэсэн шийдэлд хүрсэн байна. Тухайлбал, ус чийг, тоосны хамгаалалттай Samsung Galaxy 4 Xcover утасыг тэдэнд зориулж захиалж хийлгэсэн төдийгүй байрлал тодорхойлох функц хийсэн байна. Мөн эвхдэг жижиг нарны зай, Галнаас үүссэн дулааны энергийг цахилгааны энерги болгон хувиргадаг Японы тусгай Natsuden Nabe хоол хийдэг тогоог тэдэнд авч өгсөн

байна. Тогоондоо хоол хийх, ус буцалгах үедээ утсаа цэнэглэх боломжтой болжээ. Зурагнууд ашиглан (нийт 59 зураг бүхий) хууль бус үйлдлийг тодорхойлж хадгалах боломжтой программыг мөн зохиожээ. Утасны ашиглагдахгүй эпликэйшнийг устгасан тул утасны цэнэг нь удаан ашиглагдах боломжтой болсон байна. 2012 онд тэд утас ашиглаж 427 ажиглалтын тэмдэглэл хөтлөж, 151 зураг авч, 40 дууг хурааж чаджээ (12).

Конго улсын жишээнээс дараах гол зүйлүүдийг суралцах боломжтой гэж бид дүгнэж байна. Үүнд:

- Нутгийн иргэдийн хувьд зэрлэг амьтан нь аж амьдралаа залгуулж ирсэн амьжиргааны гол тогтвортой эх үүсвэр байсан тул тэд зэрлэг амьтныг хамгаалах нь өөрсдийгөө хамгаалж байгаатай ялгаагүй гэсэн хандлагатай байсан. Өөрөөр хэлбэл зэрлэг амьтад тэдний хувьд амьжиргааны чухал үнэ цэнэтэй нөөц баялаг байсан тул тэд зэрлэг амьтадын худалдааны гол эх уурхай

болсон хулгайн агнууртай тэмцэхэд оролцох хүсэл эрмэлзэл өндөртэй байсан.

- Ямар ч хүнд хэцүү нөхцөлд тухайн нөхцөлд байдалд тохирсон үр дүнтэй шийдлийг олж болдогийг энэ туршлага харуулж байна.
- Техник технологийн дэвшлийг ашиглан нутгийн иргэд бичиг үсэг тайлагдаагүй ч үнэ цэнэтэй мэдээллийг цуглуулж хуулийн хэрэгжилтийг хангагч талд илгээж чадаж байсан.

Зүүн Африкийн Танзани улсын туршлага

Экологийн чухал зурвас газруудад хулгайн агнуурыг бууруулах зорилготой Рувумагийн Зааны төслийг 2011 онд эхлүүлжээ. Энэ төслийн хүрээнд 3 км хашаа барьж газар тариалан эрхлэгчдийн тариаланг заанаас хамгаалсан нь зуун хувь үр дүнтэй

байсан байна. “Байгальтай зохицон амьдрахуй” нэртэй сурталчилгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, мөн 200 гаруй ард иргэдийг ажлын байраар хангаж, хулгайн агнуурын эргүүл хийлгэснээр хэд хэдэн хулгайн агнуурыг илрүүлж, хууль бус худалдааг зогсоож, хууль бус мод бэлтгэл, урхи тавих, хор тавих үйл ажиллагаа бараг зогссоны уламаас зэрлэг амьтны тоо толгой өссөн байна.

Хулгайн агнуурын эргүүл хийдэг иргэдийг сургалтанд хамруулж, тэд байгаль хамгаалагчидтай хамтран ажиллан, үйл ажиллагааныхаа үзүүлэлтээр урамшуулал хүртдэг тогтолцоог бий болгожээ.



Тосгоны ард иргэд зэрлэг амьтны хууль бус агнуур, хууль бус худалдаатай холбоотой сэжигтэй тохиолдлуудын талаар байгаль хамгаалагчидад цаг алдалгүй мэдээлдэг болсон байна. Хулгайн анчид болон ард иргэдийн дунд зөрчил үүссэн хэдий ч удаан хугацааны хамтын ажиллагаа, итгэлцлийн үр дүнд тэд хамтран ажилласаар байна (6).

Бид Танзани улсын туршлагаас дараах дүгнэлтэнд хүрэв. Үүнд:

- Зэрлэг амьтан болон хүмүүс хоорондийн зөрчлийг бууруулахад анхаарал хандуулсан

нь нутгийн иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлсөн.

- Хуулийн хэрэгжилтийг хангагч талд нутгийн иргэд мэдээлэл өгдөг хөшүүргийг бий болгосон нь үр дүнтэй болсон.
- Урт хугацааны хамтын ажиллагаа, итгэлцэл бий болсон.



Непал улсын Читваны байгалийн цогцолборт газарт хирсний хулгайн агнуур, хууль бус худалдааг бууруулсан туршлага

Хирсний тоо толгой Непал улсад 1950-иад оны үед 800 гаруй байсан бөгөөд 1960-аад оны дундуур гэхэд 100 болтлоо огцом буурчээ (5). Үүний үндсэн шалтгаан нь хууль бус агнуур, амьдрах орчны хомсдол, идэш тэжээлийн хомсдол зэрэгтэй холбоотой байв. Азийн орнуудад ялангуяа Хятад, Вьетнам зэрэг улсуудад хирсний эврийг уламжлалт эмчилгээнд өргөнөөр хэрэглэдэг явдал нь хирсний эврийн эрэлтийг бий болгодог байна. 1996 оноос 2006 оны хооронд Непалд болсон иргэний дайн нь хуулийн хэрэгжилтийг сулруулж хирсний тоо толгой дахин буурахад мөн нөлөөлсөн байна.

Непал улсын хирсний тоо толгойн 94 хувь нь Читваны Байгалийн Цогцолбор Газарт амьдардаг байна. Читваны Байгалийн Цогцолбор Газар 1973 онд байгуулагджээ. Энэ цогцолбор газар байгуулагдахаас өмнө тэр газарт 26 тосгон байсан бөгөөд эдгээрийн 25 тосгоны хүн ардыг хүчээр нүүлгэн шилжүүлж байжээ (9). Энэ үйл явдал нь эдгээр хүмүүсийн амьжиргаанд хүнд цохилт болсон бөгөөд тэдэнд ямар ч нөхөн олговор, тусламж өгөөгүй байна (10). Энэ үйл



ажиллагаа нь олон улсын хэмжээнд хүчтэй шүүмжлэлийг дагуулж байжээ.

1980-аад оноос нутгийн иргэдэд түшиглэсэн ой хамгааллыг хэрэгжүүлж эхлэн, 1996 оноос Тусгай Хамгаалалттай Газрын Орчны Бүсийн Менежментийн Журмаар нутгийн иргэдийг байгаль хамгаалалд оролцуулах арга хэмжээг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна. 2006 онд дууссан иргэний дайны дараагаар Непал улсын засгийн газраас хирсийг хамгаалахад нутгийн иргэдийг оролцоог нэмэгдүүлж эхэлжээ. Хуулийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч 2011 оноос 2015 оны хооронд Непалын армийн тусламжтайгаар эмх замбараагүй хулгайн агнуурыг бууруулж чаджээ (16).

Ой, зэрлэг амьтан, байгалийн нөөцийг үр ашигтай, тогтвортой хамгаалах, хулгайн агнууртай тэмцэх ажлын хүрээнд бүх түвшний төрийн болон олон улсын байгууллагуудын хамтран ажиллаж **“Нутгийн иргэдэд түшиглэсэн хууль бус агнууртай тэмцэх нэгж”** -үүдийг улс орон даяар олноор үүсгэн байгуулж чадсан байна. Эдгээр нэгжүүд нь хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн иргэдийн зэрлэг амьтныг хамгаалах талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хүн зэрлэг амьтны хоорондын зөрчлийг шийдвэрлэх, улмаар зэрлэг амьтантай холбоотой гэмт хэргүүдийг илрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж байв (14).

2010 оноос Читван болон бусад газруудад хууль бус агнууртай тэмцэх залуучуудын хөдөлгөөнүүд хүчтэй өрнөсөн байна.

Зөвхөн 2014-2016 онуудад Читван болон өөр 8 тусгай хамгаалалттай нутгийн орчны бүсэд нийт 58 нутгийн иргэдэд түшиглэсэн нэгжүүд үүсгэн байгуулагдсан байв. 2012 он гэхэд улсын хэмжээнд нийт 331 нэгж идэвхтэй ажиллаж байв. Дэлхийн Зэрлэг амьтныг хамгаалах өдрийг (3-р сарын 3) жил бүр тэмдэглэж энэ өдөр “Нутгийн иргэдэд түшиглэсэн хууль бус агнууртай тэмцэх нэгж”-үүдийн ололт амжилтыг тэмдэглэн урамшуулдаг заншилтай болсон нь нутгийн иргэдийг улам идэхжүүлэх нэг механизм болсон байна.

© Mangleswori Dhonju



Мөн түүнчлэн 2012 оноос эхлэн эргүүл шалгалт хийхэд өөрөө нисдэг төхөөрөмж (дрон) ашигладаг болсон нь хүн хүрэхэд амаргүй газар нутгуудад хулгайн агнуур хийж буй анчдыг хянахад ихээхэн ач тустай болсон. Үүнээс гадна орон зайн тусгай программ хангамжууд, хэрэгсэлүүдийг ашигладаг болсоноор зэрлэг амьтны хууль бус гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг улам үр дүнтэй болгож, эргүүл хийж буй болон бусад хүний хүчээ хааш нь илүү чиглүүлэх зэргийг тодорхойлоход чухал ач холбогдлтой байв. Непалийн цэргийн ангиуд үнэрч нохдыг сурган мөн энэхүү ажиллагаанд оролцуулсан нь онцгой үр дүнтэй болсон.

Хулгайн ан, хууль бус худалдаа наймаатай тэмцэх бүтэц зохион байгуулалтыг үндэсний болон орон нутгийн түвшинд бий болгож Зэрлэг ан амьтны гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хороо, Ан амьтадын гэмт хэргийг хянах товчоог үндэсний болон орон нутгийн түвшинд, нутгийн иргэдэд түшиглэсэн нэгжүүдийг орон нутгуудад ажиллуулсан. Мөн Цагдаагийн төв мөрдөн байцаах газрын харьяан дор “Зэрлэг ан амьтны гэмт хэргийг хянах товчоо”- г үүсгэн байгуулан ажилласан байна.

Хуулийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарч хууль хяналтын, гаалийн, цэргийн, тагнуулын, цагдаагийн байгууллагуудыг татаж оролцуулан тэдний нөөц, мэдлэг, туршлагыг дайчлахын сацуу байгаль орчныг хамгаалах байгууллагууд, нутгийн иргэдийн болон

залуучуудын байгууллагууд, олон улсын байгууллагуудтай нягт хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллахад анхаарчээ. Засгийн газраар удирдуулсан хууль хүчний болон хууль сахиулах байгууллагуудын багийн ажил, хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааны цар хүрээ өргөжиж зэрлэг амьтны хууль бус агнуур, наймааны асуудлыг үндэсний хэмжээний тулгамдсан шийдвэрлэх асуудал болгож хуулийн хэрэгжилтийг сайжруулсан байна. Мөн хил дамнасан хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлжээ (14).

Эхний үед мэдээлэл сурталчилгаа явуулахаасаа илүү хулгайн анчдыг илрүүлж шийтгэхэд түлхүү анхаардаг байсан хандлагыг өөрчлөн нутгийн иргэдэд түшиглэсэн хууль бус агнууртай тэмцэх нэгжүүдээр дамжуулан нутгийн иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлуудыг өргөнөөр явуулах, үүнд залуучуудын байгууллагууд болон орчны бүсийн зөвлөлүүдийг оролцуулсан нь ард иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж,

хандлагыг эерэг болгоход сайнаар нөлөөлсөн байна.

Хууль бус агнуурын худалдаа наймааг илрүүлсэнээс орсон орлогын 30-50 хувийг **Орчны бүсийн санд** төвлөрүүлэн тухайн орон нутгийн хөгжил, иргэдийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулдаг болсон нь нутгийн иргэд хулгайн антай тэмцэх томоохон хөшүүрэг болсон байна (14).

Бид Непал улсын туршлагаас дараах дүгнэлтэнд хүрэв. Үүнд:

- Непал улсын туршлагаас харахад орон нутгийн ард иргэдийн дунд хуулийн талаар сурталчилгаа явуулдаггүй, тэднийг торгох, шийтгэх, тусгай хамгаалалттай газруудаас мөн түүний орчмоос хүчээр

нүүлгэн шилжүүлдэг хандлагыг өөрчлөн хамтын ажиллагааны хандлага руу шилжсэнээр илүү үр дүнд хүрч чадсан байна.

- Тус улс нь талууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулан, хуулийн хэрэгжилтийг хүчирхэгжүүлсэн байна.
- Хууль бус агнууртай тэмцэх санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлэж чадсан байна.
- Урамшууллын олон төрлийн хөшүүргий бий болгосон байна.



Олон улсын туршлагуудаас санаа авч цаашид анхаарах шаардлагатай сургамжууд

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдтэй хэрхэн хамтран ажиллаж буй олон улсын туршлагуудыг судлан үзээд Монгол улсад зэрлэг амьтадын хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдийг хэрхэн оролцуулахад дараах зүйлүүдэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Орон нутгийн ард иргэдийн дунд хуулийн талаар сурталчилгаа хийх нь мэдээлэл дутмаг байдлаас үүдэн орон нутгийн иргэд хохирол амсахаас сэргийлэхээр байна. Энэ төрлийн гэмт хэрэг гарч байгаагийн нэг томоохон шалтгаан нь хууль, эрх зүйн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг, энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэнээр гарах үр дагаврын талаар мэдээлэл хомс зэргээс болж ард иргэд зэрлэг амьтны хууль бус худалдаа наймаанд оролцдог байна. Тухайлбал, Непал улсад зэрлэг амьтны хулгайн агнуур болон худалдаанд оролцсон 100 хоригдлоос ярилцлага судалгаа авахад 70 хувь нь эдгээр хэргийг үйлдсэнээрээ өөрийгөө ямар эрсдэлд оруулж буй талаараа болон хуулийн ямар хариуцлага хүлээдэг талаар огт мэдээлэл, мэдлэггүй байсан байна. Мөн 90 хувь нь гэр бүлийнхээ эдийн засгийн үндсэн хэрэгцээг хангах, хоол хүнсний хэрэгцээг хангах зорилгоор бус харин нэмэлт орлого олох зорилгоор хулгайн агнуур хийсэн гэж хариулсан байна (15). Манай улсад ч ямар

шалтгаанаар хулгайн агнуур хийдэг, хууль бус худалдаа хийдэг болохыг судлах шаардлагатай.

- Цагдаа болон бусад хууль хэрэгжилтийн байгууллагууд орон нутгийн ард иргэдтэй хамтын ажиллагааг өрнүүлэх байдлаар зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдааг таслан зогсооход тэдний оролцоог нэмэгдүүлэх нь илүү үр дүнтэй байна.
- Орон нутгийн ард иргэдийг чадавхжуулах, тэднийг мэдээллээр хангах, байгаль хамгаалал болон зэрлэг

© Torran Murray



амьтны хамгаалалд оролцох хөшүүргүүдийг бий болгох нь зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдаатай тэмцэхэд үр дүнгээ өгдөг байна.

- Орон нутгийн ард иргэдийг оролцуулсан мэдээллийн сүлжээг байгуулах төгс загвар гэж хаана ч байхгүй. Тухайн орон нутгийн ард иргэдийн аж амьдралын онцлог, соёл, ёс заншил, нийгэм-эдийн засгийн онцлогоос хамааран тухайн орон нутгийн түвшинд хамтран ажиллах арга замыг тодорхойлох шаардлагатай. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд тэд оролцох болон оролцохгүй байх шалтгаанууд, хөшүүргүүдийг судалж ойлгох нь чухал юм.

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдийг идэвхтэй оролцуулж, амжилтанд хүрэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүд

Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд орон нутгийн ард иргэдтэй амжилттай хамтрах ажилласан туршлагуудаас харахад

© Torran Murray



амжилтын гол шалтгаан нь дараах хүчин зүйлүүдээс ихээхэн хамаарсан байна (4). Үүнд:

- орон нутгийн ард иргэдийн итгэлийг олж авах,
- орон нутгийн ард иргэдтэй удаан хугацааны хамтын ажиллагааг үүсгэх,
- нутгийн иргэдийн хэрэгцээ болон нэн тэргүүний шийдвэрлэх шаардлагатай амьжиргааны асуудлуудыг нь ойлгож мэдэх, тодорхой хэмжээгээр хамтран шийдвэрлэх,
- тэдний соёлын болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлүүдийг ойлгож хүндэтгэн үзэх.

Зэрлэг амьтны хууль бус худалдаа наймаатай тэмцэхэд нутгийн иргэдийн оролцоог хангах, тэднээс хууль бус үйлдлийн талаар мэдээлэл авах арга хэмжээнд тэд оролцох эсэх нь тэдний аюулгүй байдал бүрэн хамгаалагдсан эсэхээс хамаардаг байна. Цагдаад итгэх итгэл, хуулийн системд итгэх итгэл, тэдний аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан эсэх талаарх итгэл үнэмшил бүрдээгүй нөхцөлд ард иргэдээс мэдээлэл авах боломжгүй байна.

Мөн хулгайн агнууртай тэмцэх, энэ талаар мэдээлэл цуглуулахад ард иргэдийг оролцуулах ажлыг амьжилттай хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэдэд бодит хөшүүрэг хэрэгтэй байдаг байна. Мэдээлэл өгсөнөөр тэдэнд орж ирж буй үр өгөөж бодитоо байх хэрэгтэй байдаг.

Орон нутгийн иргэдтэй амжилттай хамтран ажиллахад нөлөөлдөг хүчин зүйлүүд

Удаан хугацааны хамтын ажиллагааг үүсгэх

Итгэлцлийг бий болгох

Амьжиргааны асуудлуудыг тодорхой хэмжээгээр хамтран шийдвэрлэх

Орон нутгийн соёлын болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлүүдийг ойлгож хүндэтгэн үзэх

Хулгайн агнуур болон зэрлэг амьтны хууль бус худалдааг илрүүлэх ажилд нутгийн ард иргэдийн оролцоо үнэлж барашгүй чухал ач холбогдолтой ч энэ үйл ажиллагаанд оролцсоноор тэд олон төрлийн эрсдэлд ордог болохыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Цагдаа болон байгаль хамгаалагч нар орон нутгийн иргэдтэй урт хугацаанд тууштай хамтын ажиллагааг өрнүүлж байж үр дүнд хүрдэг болох нь олон улсын туршлагаадаас харагдаж байна (18).

Орон нутгийн ард иргэд байгаль хамгаалал болон зэрлэг амьтны тогтвортой ашиглалтаас шууд үр өгөөж хүртдэг болон тодорхой хэмжээгээр тэдэнд эзэмшигчийн эрх үүссэнээр хууль бус үйлдлийг илрүүлэх болон мэдээлэл өгөх хөшүүрэг бий болдог байна (18).

Хөшүүргүүдийн үр өгөөж нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байдаг. Амьжиргаагаа залгуулахад нь үнэ цэнэтэй байгалийн нөөц баялгаас хүртэх эрх болон тэр нөөц баялгаас хууль бус этгээд хүртэх боломжийг хязгаарлан нутгийн иргэд болон нутгийн иргэдийн байгууллага давуу эрхтэй хүртэх нь нэг төрлийн хөшүүрэг болж өгдөг. Тэдний газар нутаг дээр хулгайн агнуур явагдаж байгааг нутгийн иргэд тэдний нөөц баялгаас хулгай хийж байгаа гэж ойлгож хүлээн зөвшөөрч байвал энэ талаар мэдээлэл өгөх эрсдэлийг даахад бэлэн байдаг (18).

Хэрэв ард иргэд цагдаа болон бусад эрх

мэдэл бүхий хүмүүсийг хахуульд автсан, шударга бус, итгэл даах найдваргүй, хариуцлагагүй гэж үзвэл тэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хуулийн хэрэгжилтийг хангах үйлдэлд оролцохоос татгалздаг байна (18).

Хууль хэрэгжүүлэгч тал буюу цагдаагийн болон бусад эрх бүхий байгууллага нь нутгийн иргэдтэй хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, хамтын ажиллагааг үүсгэж байж бие биедээ итгэх итгэл бий болдог болох нь олон улсын туршлагаас мөн харагдаж байна.

Мөн нутгийн иргэд нь өөр хоорондоо төрөл садны холбоотой, олон жилийн хөрш болон нэг хамт олон болж ажиллаж амьдарч байсан байдаг тул хууль бус үйл ажиллагаанд оролцож буй этгээдүүдийг мэдээлэхээс татгалздаг байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Олон нийтийн цагдаа нарт өгөх ЗӨВЛӨМЖ



© Д. Мөнхнаст

**Иргэдийн Төлөөлөгчдийн
хурал, олон нийтийн цагдаа
нарт өгөх зөвлөмжийн тухай**

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Зэрлэг ан амьтны хууль бус худалдааг бууруулах, хил орчмын иргэдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн зорилтод зөвлөмж

боловсруулахаар заасан тул бид олон улсын туршлага, төслийн хэрэгжилтийн үр дүн, тайлан, Монгол улсын бодлого, хууль эрх зүйн орчныг судласны үндсэн дээр зөвлөмжийг боловсрууллаа.

Зөвлөмжийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, олон нийтийн цагдаа нарт зориулж өгсөн бөгөөд зөвлөмж нь хоёр хэсэг, долоон бүлэг, дөчин есөн заалтаас бүрдэж байгаа болно.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгөх зөвлөмжийн тухай

Орон нутгийг хөгжүүлэх урт болон богино хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөнд зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаар тусгаж өгч байх талаар зөвлөмжинд тусгасан. Ингэснээр зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээний хэрэгжилтэнд шат шатанд хяналт тавьж ажиллах механизм бий болно.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээг орон нутгийн түвшинд тулгамдсан асуудлуудын нэг болгож ажиллаж чадвал Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээг санхүүжүүлэх, амжилттай хэрэгжүүлэх боломж нээгдэнэ.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлд олон нийтийн анхаарлыг хандуулсан, хандлагыг өөрчилсөн, олон нийтийг хамарсан

арга хэмжээ зохион байгуулах талаар зөвлөмж өгсөн. Ингэснээр ард иргэдийн Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсооход оролцох идэвх нэмэгдэнэ гэж үзэж байна.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаарх аливаа үйл ажиллагааг алдаа дутагдалтай байсан ч хамтдаа суралцангаа хийх зарчмыг баримталж ажиллах шаардлагатай. Ингэснээр аль аль тал нь суралцан Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоохтой холбоотой арга хэмжээ, үйл ажиллагаа нь улам сайжирч, хэрэгжих болно.

Байгалийн баялгаас орж ирж байгаа орлогыг олон нийтэд нээлттэй байлгаж, шилэн дансыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгсөн. Ингэснээр ард иргэд байгалиас бидэнд, ард түмэнд тодорхой хөрөнгө оруулалт орж ирдэг юм байна гэсэн мэдээлэлтэй болж, байгаль хамгаалах ажилд идэвхтэй оролцох эрмэлзэлтэй болно.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлийн

албан хаагчид тухайлбал, олон нийтийн цагдаа, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар улсын болон бүс нутгийн хэмжээний платформтой байх ажлыг санаачилж, дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай. Ингэснээр албан тушаалтнууд байгаль орчны эсрэг гэмт хэргийн мэдээллийг түргэн шуурхай авч, сонор сэрэмжтэй байж, урьчилан сэргийлэх арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулахад түлхэц болно.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд хууль тогтоомжийн хүрээнд төсөв батлах, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр салбар дундын зохицуулалтыг хангаж ажиллах, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр амжилттай хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчилж байх, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр орон нутгийн түвшинд хяналт шалгалтыг салбар дундын оролцоог хангаж явуулж байх зэрэг зөвлөмжийг мөн өгсөн. Эдгээр арга хэмжээнүүдийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үндсэн чиг үүрэг, эрх мэдлийнхээ хүрээнд зохион байгуулан хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох асуудалтай хууль тогтоомжийн талаарх сурталчилгааг тогтмол яваалж байх, ялангуяа шинэчлэгдсэн болон шинээр гарсан хууль тогтоомжийг цаг алдалгүй ард иргэдэд шуурхай сурталчилж байх хэрэгтэй. Орон нутгийн ард иргэдийн дунд хуулийн талаар

сурталчилгаа хийх нь мэдээлэл дутмаг байдлаас үүдэн орон нутгийн иргэд хохирол амсахаас сэргийлэх болно.

Зэрлэг ан амьтны хулгайн анчид, зэрлэг ан амьтны хууль бус худалдаа хийгч, зөөвөрлөгч нар болон тэдгээртэй тодорхой байдлаар холбоотой иргэдийг хэт ялгавларлан үзэх, хууль тогтоомжийг хэт тулган шаардах нь ард иргэдтэй хамтран ажиллахад хаалт болдог тул уян хатан бодлого баримталж, ажиллах шаардлагатай байдаг.

Хил дамнасан хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны бичиг баримтанд зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаар тусгаж өгөх, хөрш орны ард иргэдэд Монгол улсын хууль эрх зүйн талаар мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа хийх, хөрш орны иргэдийн тухайн эко аялал жуулчлалыг орон нутагтаа хөгжүүлэх талаар зөвлөмж өгсөн байгаа. Ингэснээр, хөрш орны иргэд манай талаас авч байгаа ан амьтны эд эрхтэн нь Монголд олон хууль, тогтоомж зөрчиж байдаг, хуулийн хариуцлага хүлээдэг талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй болж, тухайн

амьтныг худалдаж авах эрмэлзэл тодорхой хэмжээгээр буурах болно.

Тухайн орон нутгийн ард иргэдийхээ аж амьдралын онцлог, соёл, ёс заншил, нийгэм-эдийн засгийнхаа онцлогтой уялдуулж, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр ард иргэдтэй орон нутгийн түвшинд хамтран ажиллах арга замыг тодорхойлж, ажиллах, нутгийн иргэдийг зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаарх мэдээллийг хэрхэн өгөх, ямар тохиолдолд мэдээлэл өгөх чиглэлээр сургалтанд хамруулах талаар мөн зөвлөмж өгсөн. Яагаад гэвэл юуг сэжигтэй тохиолдол гэж мэдээлэл өгөх шаардлагатай, хэдийд хэнд мэдээлэл өгөх, мэдээллийн нууцыг хэрхэн хадгалах талаар ард иргэд мэдлэг, мэдээлэл хомс байдаг тул нутгийн ард иргэд дээрх арга хэмжээнд оролцох оролцоо бага байдаг.

Орон нутагтаа холбогдох хууль тогтоомжийн дагуу нутгийн иргэдийг урамшуулах систем, эдийн засгийн хөшүүргийг бий болгох шаардлагатай байна. Энэ талаар хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн байгаа. Урамшууллыг улс болон орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сангийн хөрөнгө, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээнээс санхүүжүүлж болно.

Орон нутгийн аливаа байгаль хамгаалах чиглэлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэнд ард иргэдийг эхнээс идэвхтэй оролцуулж байх хэрэгтэй. Ингэснээр тэдгээрийг Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсооход саадгүй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ

Оролцооны аргыг ашиглан зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх

© Д. Лхагвасүрэн



тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд ард иргэдийг хэрхэн идэвхтэй оролцуулах чиглэлээр мэргэшсэн нийгмийн шинжлэх ухааны судлаачидтай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй болох нь олон улсын туршлагаас харагдсан.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллах зорилтот бүлгийг зөв тодорхойлж, ажиллах, хамтран ажиллах зорилтот бүлгийн ард иргэдийг чадавхжуулах, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр нутгийн иргэдийг зохион байгууллалтанд оруулж чадавхжуулах ажлыг зохион байгуулах, орон нутгийн ард иргэдтэй зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр олон жилийн, урт хугацааны бий болгож, ажиллах зэрэг зөвлөмжийг өгч байна. Ингэснээр Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд ард иргэдийн идэвх оролцоо нэмэгдэх болно.

Орон нутгийн иргэд өөрсдөө зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр болон хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгааг ард иргэдийн дунд хийх нөхцлийг бүрдүүлж ажиллах, Яагаад гэвэл ард иргэд албан тушаалтнуудаас илүүтэй өөрсдийгөө илүү сайн сонсож хүлээн авдаг.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр орон нутгийн эмэгтэйчүүдийг хамруулан ажиллах талаар санаачлага гарган ажиллах шаардлагатай байгаа талаар мөн техник технологийн дэвшлийг

ашиглан нутгийн иргэдийн мэдээллийг цуглуулж, хуулийн хэрэгжилтийг хангагч талд илгээх, нууцыг чандлан хадгалах системийг бий болгож, ажиллах талаар зөвлөмжинд тусгасан болно.

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр ард иргэд оролцсон нэгж ажиллуулах шаардлагатай. Ингэснээр ард иргэдийн оролцоог илүү бодитой, үр бүтээлтэй болгоно.

Олон нийтийн цагдаа нарт өгөх зөвлөмжийн тухайд

Цагдаад итгэх итгэл, хуулийн системд итгэх итгэл, тэдний аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан эсэх талаарх итгэл үнэмшилийг ард иргэдэд бий болгож ажиллах тал дээр анхаарах талаар зөвлөмж болгосон. Ер нь бол Цагдаад итгэх итгэл, хуулийн системд итгэх итгэл, тэдний аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан эсэх талаарх итгэл үнэмшилийг ард иргэдэд бий болгоогүй тохиолдолд ард иргэдээс мэдээлэл авах боломжгүй байдаг байна.

Зэрлэг ан амьтны хууль

бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд нутгийн ард иргэд оролцсоноор тэд олон төрлийн эрсдэлд ордог болохыг анхаарч ажиллах хэрэгтэй. Хулгайн агнуур болон зэрлэг амьтны хууль бус худалдааг илрүүлэх ажилд нутгийн ард иргэдийн оролцоо үнэлж барашгүй чухал ач холбогдолтой ч энэ үйл ажиллагаанд оролцсоноор тэд олон төрлийн эрсдэлд ордог болохыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Цагдаа болон байгаль хамгаалагч нар орон нутгийн иргэдтэй урт хугацаанд тууштай хамтын ажиллагааг өрнүүлж байж үр дүнд хүрдэг болох нь олон улсын туршлагаудаас харагдаж байгаа тул орон нутгийн иргэдтэй урт хугацаанд тууштай ажиллах чиглэлээр зөвлөмж өгсөн.

Хууль хэрэгжүүлэгч тал буюу цагдаагийн болон бусад эрх бүхий байгууллага нь нутгийн иргэдтэй хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, хамтын ажиллагааг үүсгэж байж бие биедээ итгэх итгэл бий болдог болох нь олон улсын туршлагаас мөн харагдаж байна. Иймд нутгийн иргэдтэй хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, хамтын ажиллагааг үүсгэж, ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

Нутгийн иргэдийн хэрэгцээ болон нэн тэргүүний шийдвэрлэх шаардлагатай амьжиргааны асуудлуудыг нь ойлгож мэдэх, тодорхой хэмжээгээр хамтран шийдвэрлэх, тэдний соёлын болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлүүдийг ойлгож хүндэтгэн үзэх талаар



зөвлөмжинд тусгасан. Ингэснээр нутгийн иргэдийн оролцоо нэмэгдэх болно.

Цагдаа нар эрчүүдтэй хамтран ажиллах чиглэл барих хандлагатай байдаг, үүн дээр анхаарч эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй хамтарч ажиллах талаар зөвлөмж өгсөн.

ЗӨВЛӨМЖ

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

Нэг. Орон нутагт зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан



зогсоох арга хэмээг бодлогоор хангаж ажиллах чиглэлээр

1.1. Орон нутгийг хөгжүүлэх урт болон богино хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөнд зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаар тусгаж өгч ажиллах,

1.2. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээг орон нутгийн түвшинд тулгамдсан асуудлуудын нэг болгох,

1.3. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлд олон нийтийн анхаарлыг хандуулсан, хандлагыг өөрчилсөн, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах,

1.4. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаарх аливаа үйл ажиллагааг алдаа дутагдалтай байсан ч хамтдаа суралцангаа хийх зарчмыг баримталж ажиллах,

1.5. Байгалийн баялгаас орж

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд

Зэрлэг амьтны хууль бус агнуур болон худалдаатай тэмцэх, тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээг бодлогоор хангаж ажиллах чиглэлээр



ирж байгаа орлогийг олон нийтэд нээлттэй байлгаж, шилэн дансыг хэрэгжүүлэх,


1.6. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлийн албан хаагчид тухайлбал, олон нийтийн цагдаа, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар улсын болон бүс нутгийн хэмжээний платформтой байх ажлыг санаачилж, дэмжлэг үзүүлэх,

1.7. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан

зогсоох арга хэмжээнд хууль тогтоомжийн хүрээнд төсөв батлах,

1.8. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр салбар дундын зохицуулалтыг хангаж ажиллах,

1.9. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай



тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр амжилттай хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчилж байх,

1.10. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр орон нутгийн түвшинд хяналт шалгалтыг салбар дундын оролцоог хангаж явуулж байх.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр

2.1 Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох асуудалтай хууль тогтоомжийн талаарх сурталчилгааг тогтмол яваалж байх, ялангуяа шинэчлэгдсэн болон шинээр гарсан хууль тогтоомжийг цаг алдалгүй ард иргэдэд шуурхай сурталчилж байх,

2.2 Зэрлэг ан амьтны хулгайн анчид, зэрлэг ан амьтны хууль бус худалдаа

хийгч, зөөвөрлөгч нар болон тэдгээртэй тодорхой байдлаар холбоотой иргэдийг хэт ялгавларлан үзэх, хууль тогтоомжийг хэт тулган шаардах нь ард иргэдтэй хамтран ажиллахад хаалт болдог тул уян хатан бодлого баримталж, ажиллах.

Гурав. Зэрлэг амьтны эд эрхтнийг хэрэглэгч талын эрэлтийг бууруулах чиглэлээр

3.1. Хил дамнасан хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны бичиг баримтанд Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаар тусгаж өгөх,

3.2. Хөрш орны ард иргэдэд Монгол улсын хууль эрх зүйн талаар мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа хийх,

3.3. Хөрш орны иргэдийг оролцуулсан эко аялал жуулчлалыг орон нутагтаа хөгжүүлэх,

3.4. Зэрлэг амьтадын эд эрхтэнийг орлуулах бүтээгдэхүүнийг бий болгох, хөрш орнуудад санал болгох ажлыг зохион байгуулах,

Дөрөв. Хууль бус үйлдлийг илрүүлэх ажиллагаанд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, **хамтран ажиллах** чиглэлээр

4.1. Тухайн орон нутгийн ард иргэдийг аж амьдралын онцлог, соёл, ёс заншил, нийгэм-эдийн





засгийнхаа онцлогтой уялдуулж, зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр ард иргэдтэй орон нутгийн түвшинд хамтран ажиллах арга замыг тодорхойлж ажиллах, мэдээллийн сүлжээг байгуулах,

4.2. Нутгийн иргэдийг зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаарх мэдээллийг хэрхэн өгөх, ямар тохиолдолд мэдээлэл өгөх чиглэлээр сургалтанд хамруулах,

4.3. Орон нутагтаа холбогдох хууль тогтоомжийн дагуу нутгийн иргэдийг урамшуулах систем, эдийн засгийн хөшүүргийг бий болгох,

4.4. Орон нутгийн аливаа байгаль хамгаалах чиглэлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэнд ард иргэдийг эхнээс идэвхтэй оролцуулах,

4.5. Оролцооны аргыг ашиглан зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд ард иргэдийг хэрхэн идэвхтэй оролцуулах чиглэлээр мэргэшсэн нийгмийн шинжлэх ухааны судлаачидтай хамтран ажиллах,

4.6. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллах зорилтот бүлгийг зөв тодорхойлж, ажиллах, хамтран ажиллах зорилтот бүлгийн ард иргэдийг чадавхжуулах,

4.7. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр нутгийн иргэдийг зохион байгууллалтанд оруулж чадавхжуулах ажлыг зохион байгуулах,

4.8. Орон нутгийн ард иргэдтэй зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр олон жилийн, урт хугацааны хамтын ажиллагааг бий болгож, ажиллах,

4.9. Орон нутгийн иргэд өөрсдөө зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр болон хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгааг ард иргэдийн дунд хийх нөхцлийг бүрдүүлж ажиллах,

4.10. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр орон нутгийн эмэгтэйчүүдийг хамруулан ажиллах талаар

санаачлага гаргах,

4.11. Т е х н и к технологийн дэвшлийг ашиглан нутгийн иргэдийн мэдээллийг цуглуулж, хуулийн хэрэгжилтийг хангагч талд илгээх, нууцыг чандлан хадгалах системийг бий болгох,

4.12. Ард иргэдийн зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох талаар өгсөн мэдээллийн нууцыг хадгалах чиглэлээр анхаарч ажиллах.

4.13. Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох чиглэлээр ард иргэд оролцсон нэгж ажиллуулах.

Олон нийтийн цагдаа нарт:

Нэг. Мэдлэг, хандлага, дадал

1.1. Хийсэн үр дүнтэй ажлуудаа улс орон даяар сурталчилах,

1.2. Хэвлэл мэдээллийн



хэрэгсэл, телевиз, социал/олон нийтийн сүлжээгээр энгийн ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлж, мэдлэг олгож байх. Сургалтыг өрх, багаар явж, нүүр тулсан байдлаар видео, тараах материал зэргийг өргөнөөр ашиглан явуулах,

1.3. Хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн амьтныг хайрлах, нутгийн эко системийг хамгаалах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах ажлыг сургаж, дадлагажуулах,

1.4. Орон нутгийн иргэдэд тухайн орон нутагт амьдардаг зэрлэг амьтан, тэдгээрийн экологийн ач тус, амьдрах нөхцөл, хэт цөөрч, устаж үгүй болсноор гарах үр дагаврыг сурталчлан таниулах,

1.5. Агнахыг хориглосон ан, ан хийх зөвшөөрөгдсөн хугацаа, агнах зөвшөөрөл авах тухай, агнахыг зөвшөөрсөн тоо мэдээний

талаар мэдээлэл өгч ажиллах,

1.6. Хулгайн ан, зэрлэг ан амьтан, тэдгээрийн эд эрхтэнг хууль бус худалдаалахтай холбоотой хуулийн хариуцлага, хор хөнөөл, үр дагаврын талаар мэдээлэл өгч ажиллах.


Хоёр. Хууль суртачилан таниулах чиглэлээр

2.1 Ан амьтны тухай, Байгаль орчны тухай, Мал, амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, таниулах,

2.2 Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн хариуцлагын төрөл, хэлбэрийн талаар ойлголт мэдээлэл өгөх. Холбогдох хууль тогтоомжийн товч агуулгыг хялбаршуулсан байдлаар зураг хэлбэрээр гарын авлага болгон олон нийтэд түгээх, сурталчлах.

Гурав. Нутгийн иргэдтэй хамтран ажиллах болон бусад хамтын ажиллагааг хангах чиглэлээр

3.1 Нутгийн ард иргэдтэй хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, хамтын ажиллагааг үүсгэж, ажиллах,



3.2 Нутгийн ард иргэдийн хэрэгцээ болон нэн тэргүүний шийдвэрлэх шаардлагатай амьжиргааны асуудлуудыг нь ойлгож мэдэх, тодорхой хэмжээгээр хамтран шийдвэрлэх,

3.3 Нутгийн ард иргэдийн соёлын болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлүүдийг ойлгож хүндэтгэн үзэх,

3.4 Байгалийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлийн албан хаагчид улсын болон бүс нутгийн хэмжээний платформтой байх талаар санал гаргаж ажиллах,

3.5 Цагдаад итгэх итгэл, хуулийн системд итгэх итгэл, тэдний аюулгүй байдал баталгаатай хамгаалагдсан эсэх талаарх итгэл үнэмшилийг ард иргэдэд бий болгож ажиллах тал дээр анхаарах,

3.6 Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээнд нутгийн ард иргэд оролцоноор тэд олон төрлийн эрсдэлд ордог болохыг анхаарч ажиллах,

3.7 Орон нутгийн иргэдтэй урт хугацаанд тууштай ажиллах,

3.8 Орон нутгийн төрийн, төрийн бус байгууллага, олон улсын төсөл, хөтөлбөртэй хамтарч ажиллах (*Байгаль Орчны Хяналтын Улсын Байцаагч, байгаль хамгаалагч нар, малчдын байгууллагууд, сургууль, цэцэрлэг,*

соёлын төв, гм),

3.9 Иргэдээс мэдээлэл авах, мэдээллийн нууцлалыг хангах чиглэлээр хамтран ажиллах,

3.10 Цагдаа нар эрчүүдтэй хамтран ажиллах чиглэл барих хандлагатай байдаг, үүн дээр анхаарч эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй хамтарч ажиллах,

3.11 Цагдаа болон бусад хууль хэрэгжилтийн байгууллагууд орон нутгийн ард иргэдтэй хамтын ажиллагааг өрнүүлэх байдлаар зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдааг таслан зогсоход чиглэж ажиллах.

Дүгнэлт

© Д. Лхагвасүрэн

1. Зэрлэг амьтны хууль бус худалдаанд нийгмийн янз бүрийн бүлгүүд оролцдог, энэ нь нарийн нийлмэл процесс учраас олон талт шийдлүүд, олон төрлийн арга замаар тэмцэх нь илүү үр дүнтэй тул улс орны хэмжээнд үндэсний хэмжээний стратеги төлөвлөгөө боловсруулж ажиллах нь богино хугацаанд үр дүнд хүрэх боломжийг бүрдүүлдэг. Зарим улс орнууд зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэх талаарх үндэсний хэмжээний бие даасан бодлого болон стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласнаар тодорхой үр дүн хүрсэн байна.

2. Бид олон улсын туршлагыг судлан үзэж, эмхтэн нэгтгэн дүгнэхэд зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсоох арга хэмжээг үр бүтээлтэй хэрэгжүүлэхэд бодлогоор хангах, зэрлэг амьтны эд эрхтэнийг хэрэглэгч талын эрэлтийг бууруулах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хууль бус үйлдлийг илрүүлэх ажиллагаанд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллаж байгаа нь харагдаж байна.



3. Олон улсын туршлагаас харахад нутгийн ард иргэдийг Зэрлэг ан амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх тэдгээрийг таслан зогсооход оролцуулахдаа тухайн орон нутгийн ард иргэдийн аж амьдралын онцлог, соёл, ёс заншил, нийгэм-эдийн засгийн онцлогтой уялдуулах хэрэгтэй ба урамшуулал, эдийн засгийн хөшүүргийг бий болгох, аливаа арга хэмжээнд эхнээс нь идэвхтэй оролцуулах нөхцөлийг хангах, оролцооны аргыг хэрэглэх, зорилтот бүлэг, ард иргэдийн нэгжийг ашиглах, нутгийн иргэдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулах, чадавхжуулах, нутгийн иргэдийг өөрсдөөр нь сургалт, сурталчилгаа явуулах, жендерийн тэгш байдлыг хангах, харилцаа холбооны техникийн дэвшлийг ашиглах, нэвтрүүлэх, мэдээллийн нууцыг чандлан хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллавал илүү

үр дүн хүрдэг байна.

4. Бид хоёр бүлэг, долоон хэсэг дөчин есөн заалт бүхий зөвлөмжийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, олон нийтийн цагдаа нарт зориулан боловсруулан гаргаж байна. Эдгээр зөвлөмжүүд нь олон улсын туршлагыг үндэслэн, Монгол улсын нөхцөл байдалтай уялдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, олон нийтийн цагдаа эрх үүрэг, ажил үүрэгт нийцүүлэн, судалгаатайгаар боловсруулсан тул хэрэгжүүлэх бүрэн боломжтой болно.



Ном зүй

1. Annette Hubschle & Clifford Shearing. 2018. *Ending wildlife trafficking: Local communities as change agents. Global Initiative Against Organized Crime*. Geneva. Switzerland.
2. Batbold, J. 2002. The problems of management of marmots in Mongolia. In: K.B. Armitage and V.Y. Rumiantsev (eds.) *Holarctic marmots as a factor of biodiversity, proceedings of the third international conference on marmots*. Cheboksary. pp. 68-75. (In English and Russian)
3. Clark, E.L., Munkhbat, J., Dulamtseren, S., Baillie, J.E.M., Batsaikhan, N., Samiya, R. and Stubbe, M. (compilers and editors) 2006. *Mongolian Red List of Mammals. Regional Red List Series*. Zoological Society of London. (In English and Mongolian).
4. Cooney, R., Roe, D., Dublin, H. and Booker, F. 2018. *Wild life, Wild Livelihoods: Involving Communities in Sustainable Wildlife Management and Combatting the Illegal Wildlife Trade*. United Nations Environment Programme, Nairobi, Kenya.
5. Christian Nellemann et al, 2014. *The environmental crime crisis – Threats to sustainable development from illegal exploitation and trade in wildlife and forest resources*. A UNEP rapid response assessment. Nairobi: United Nations Environment Programme and GRID-Arendal, 32.
6. Dilys R et al. 2015. *Beyond enforcement symposium: Engaging communities in tackling wildlife crime*. Briefing.
7. Dilys Roe & Francesca Booker. 2018. *Engaging local communities in tackling illegal wildlife trade: A synthesis of approaches and lessons for best practice*. Review. Conservation Science and Practice. A Journal of the Society of Conservation Biology.
8. Duan Biggs, Rosie Cooney, Dilys Roe, Holly Dublin, James Allan, Dan Challender and Diane Skinner. 2015. Engaging local communities in tackling illegal wildlife trade: Can a Theory of Change help? IEED Discussion Paper, London. www.iied.org/pubs
9. Joanne McLean. 1999. Conservation and the impact of relocation on the Tharus of Chitwan, Nepal. HIMALAYA, the Journal of the Association for Nepal and Himalayan Studies, 19 (1999), 40.
10. Narayan P Dhakal, Kristen C Nelson and JL David Smith. 2011. Resident well-being in conservation resettlement: The

- case of Padampur in the Royal Chitwan National Park, Nepal, *Society & Natural Resources*, 24, 6 (2011/04/22 2011), 597–615, 600.
11. Mallon D.P. 2008. *Saiga tatarica*. The IUCN Red List of Threatened Species 2008.
 12. Michalis Vitos, Jerome Lewis, Matthias Stevens and Muki Haklay, 2013. *Making local knowledge matter: Supporting non-literate people to monitor poaching in Congo*. Annual Symposium on Computing for Development of Association for Computing and Machinery. Dev'13, January 11-12, 2013, Bangalore, India.
 13. https://www.justice.gov/sites/default/files/enrd/legacy/2015/04/13/National_Strategy_for_Combating_Wildlife_Trafficking_-_Implementation_Plan.pdf
 14. Oyuntulkuur, B. 2020. Report on the CITES training consultant. Zoological Society of London's Representative office in Mongolia. Ulaanbaatar.
 15. Rachel Nuwer. 2020. A novel study in Nepal shines light on why people commit wildlife crime and how others might be dissuaded from doing so in future.
 16. Richard Emslie et al. 2016. African and Asian rhinoceroses – status, conservation and trade: A report from the IUCN Species Survival Commission (IUCN SSC) African and Asian Rhino Specialist Groups and Traffic to the Cites Secretariat pursuant to Resolution Conf. 9.14 (Rev. Cop15), Geneva: CITES Secretariat, 14.
 17. US Fish & Wildlife Service. Newsletter-*Conservation in Human Demension*. 2020 Issue 10.
 18. USAID Biodiversity Technical Brief. David Wilkie, Michael Painter and Anila Jacom. 2016. *Measuring Impact: Rewards and risks associated with community engagement in anti-poaching and anti-trafficking*.
 19. <https://www.scientificamerican.com/article/to-stop-wildlife-crime-conservationists-ask-why-people-poach/>
 20. Wingard J.R. and P. Zahler. 2006. Silent Steppe: The Illegal Wildlife Trade Crisis in Mongolia. Mongolia Discussion Papers, East Asia and Pacific Environment and Social Development Department. Washington D.C. World Bank.
 21. WRIGHT, E., BHAMMAR, H. & GONZÁLEZ-VELOSA, A. 2016. Analysis of international funding to tackle illegal wildlife trade. World Bank Group, Washington, DC, US.

Талархал

Холбогдох тайлан, гэрээ, бичиг баримтаар хангаж хамтран ажилласан Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол улс дахь төлөөлөгчийн газрын захирал У.Тунгалаг, төслийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал болон тус төлөөлөгчийн газрын хамт олонд талархаж байна. Тайланд зориулан зургаа илгээсэн Б.Ганхуяг, Д.Лхагвасүрэн, Д.Мөнхнаст, Enock Senteu, Torran Murray, Mangleswori Dhonju нарт талархаж байна.

© Д. Лхагвасүрэн



**ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС
ХУДАЛДААТАЙ ТЭМЦЭХЭД ОРОН
НУТГИЙН ИРГЭДТЭЙ ХАМТРАН
АЖИЛЛАЖ БУЙ ОЛОН УЛСЫН
ТУРШЛАГА**

Холбогдох хаяг:

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн
Монгол дахь төлөөлөгчийн газар,
Монре импекс ХХК-н байр, 302 тоот өрөө, Бага тойруу-47,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар Хот, Монгол улс.
Утас: 77111138

© Д. Мөнхнаст

